



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-42

1.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 6-27

2.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 27-42

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороодын
2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр /Даваа гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 49 гишүүнээс 27 гишүүн хүрэлцэн ирж, 56.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 40 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Д.Батбаяр, Ж.Ганбаатар, Г.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Б.Мөнхтулга, Н.Наранбаатар, Н.Номтойбаяр, Б.Түвшин, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр, Л.Энхнасан, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, С.Эрдэнэболд.

Нэг Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, Төлөвлөлтийн инженерийн албаны дарга А.Баяржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нар танилцуулав.

Танилцуулга болон санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Б.Заяабал, Д.Ганбат, Х.Ганхуяг, Р.Батболд, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ч.Анар, Д.Ганбат, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг зөвшөөрье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 20
Бүгд: 20
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал санал хураалтын төхөөрөмж ажиллахгүй байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулъя гэсэн горимын санал гаргав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 12
Бүгд: 32
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 12
Бүгд: 32
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг зөвшөөрье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 13
Бүгд: 32
59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.01.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн захирал Б.Дашдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нар танилцуулав.

Танилцуулга болон санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, Г.Хосбаяр, Д.Ганбат нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг зөвшөөрье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Г.Тэмүүлэн: Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг зөвшөөрье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 12
Бүгд: 32
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 17 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 49 гишүүнээс 31 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 16 цаг 06 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. 2 байнгын хорооны хамтарсан хуралдаан өнөөдөр хийхээр байгаад байгаа.

Зээлийн хэлэлцээртэй холбогдуулаад Төсвийн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны өнөөдрийн хуралдааны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Хоёр Байнгын хорооны гишүүдийг нэгтгээд уншиж уншаад танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн хүрэлцэн ирсэн байна, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажикберийн Жангабыль гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн, Тилеуханны Аубакир гишүүн, Ренчиндоржийн Батболд гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Дамбын Батлут гишүүн, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Хассуурийн Ганхуяг, гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Загджавын Мэндсайхан, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр 2 Байнгын хорооны өнөөдрийн хуралдааны ирц бүрдсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны хамтарсан хуралдааны ирц бүрдсэн тул 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя 2 асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын 4 дүгээр багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт, Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төсөл Засгийн газар 2025 оны нэгдүгээр сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн зөвшилцөх асуудал байна.

Хоёр дахь асуудал нь Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах эрчим хүч 3 төслийн зээлийн хэлэлцээрийн төсөл, Засгийн газар мөн 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр ирүүлсэн зөвшилцөх асуудал байна аа.

хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын 4 дүгээр багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ингээд хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Засгийн газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулахыг хүсье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулж байна.

Засгийн газраас асуудлаа танилцуулахаар орж ирж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрсийг та бүхэнд танилцуулъя.

Жавхлан сайд орж ирэх ёстой байгаа. Сангийн яамнаас Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Аж үйлдвэр эрдэс баялгийн сайд Туваан сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Сүхбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны БХЗГ-ын дарга Хишигдалай гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-аас тус компанийн гүйцэтгэх захирал Алтанцэцэг захирал, тус компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг, тус компанийн Технологийн албаны дарга Мөнх-Эрдэнэ тус компанийн төлөвлөлтийн инженерийн албаны дарга Баяржаргал гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна аа.

Сангийн сайд Жавхлан сайд хүрэлцэн ирсэн байна.

Ингээд зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Жавхлан сайд танилцуулна аа. Таныг микрофонд урьж байна. 2 номер шүү.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Эрхэм Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас БНЭУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь Хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслөөс хамгийн түрүүнд үйл ажиллагаа нь хэрэгжиж эхлэх өгөөжөө өгөх төсөл юм аа. Жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулах хүчин чадалтай, дотоодын хэрэглээний 55 хувийг хангаж шинээр 700 гаруй ажлын байр бий болгох эдийн засаг, стратегийн өндөр ач холбогдолтой төсөл юм аа. Улсын Их Хурлын зүгээс төслийн санхүүжилтийн шаардлагатай 1.2 тэрбум долларын зээлийн хэлэлцээрүүдийг Төслийн төслийн санхүүжилттэй гэрээг бол анх 2019 онд соёрхон баталсан юм. Анх бол төсөл тодорхойгүй байсан үед 1 тэрбум долларын асуудлыг

мөн 2017 онд Их Хурал дээр энэ асуудлыг хэлэлцэж байсан. Ингээд төсөв батлагдаад тэрнээс хойш 2024 оны жилийн эцсийн байдлаар 268.8 сая долларын эх үүсвэрийг ашиглаад байгаа бөгөөд төслийн нийт ажлын гүйцэтгэл 23.5 хувьтай байна. Төслийн хэрэгжилтийн явцад Засгийн газар БНЭУ Эксим банкны хооронд байгуулсан 1 тэрбум долларын зээлийн эргэн төлөлт нь 2023 оноос жил бүр 64.5 сая долларын өмч үндсэн төлбөр төлөгдөхөөр хуваарьтай байсан бөгөөд энийг Засгийн газрын зүгээс зардалтай хэлэлцээр хийсний үр дүнд шинэчилж чадсан. Ингээд ЕРС 2, 3 багц ажлын зээлийн санхүүжилтүүд 789 сая ам.долларын үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж хугацааг 7 жилээр сунгаж чадсан. Монгол газрын тос боловсруулах үйлдвэрээс ЕРС 4 багц ажил буюу үндсэн үйл үйлдвэрийн барилга байгууламж, газрын тос боловсруулах ажлын төсөвт өртөг гүйцэтгэгчийн ирүүлсэн саналаас хамааран нэмэгдэх талаар мэдэгдсэн бөгөөд нарийвчилсан ТЭЗҮ-г Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны харьяа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2023 оны 9 дүгээр сард хэлэлцсэн төслийн нийт өртгийг 1 тэрбум 698 сая доллар буюу хуучин төсөвт өртгөөс 464 сая доллароор нэмэгдэхээр баталгаажсан байна. Үүний дагуу Засгийн газрын зүгээс газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг БНЭУ-ын Эксим банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр засгийн хэлэлцээр хийгээд байна. Энэтхэг талаас 464 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийг ЕРС 1, 2, 3, 4 дүгээр багцын ажлын хүрээнд зарцуулагдах тул 2019 онд тус багцад ажлын хүрээнд байгуулсан 236 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийг энэ дотор нь шингээж 700 сая ам.долларын зээлийн хэлэлцээр байгуулахаар хэлэлцээрийг төсөлд тусгаад байна. Зээлийн хэлэлцээрийн төсөлд Энэтхэгийн талаас өмнөх зээлийн хэлэлцээрүүдийн нөхцөлүүдээс гадна дараах 3 шинэ нөхцөлийг тавьсан.

Үүнд:

Нэгт хэрэв нэмэлт санхүүжилтийн нөхцөл үүсэх юм бол Монголын Засгийн газар дангаараа хариуцна шүү.

Хоёрт, хэрвээ янз бүрийн дефолт үүсгэх юм бол банканд төвлөрүүлсэн нэг банкны дансаар дамжуулна тэндээс шууд бид зээлээ төлүүлнэ шүү гэсэн.

Гуравт, хэрвээ 2045 он хүртэл хэрэгжих хугацаанд янз бүрийн дефолт үүсгэх бэлдэх асуудал гарах юм бол Эксим банктай зөвшилцөж асуудлыг дундаа шийднэ шүү гэсэн. Нэг ийм 3 шинэ нөхцөл тавьсан байгаа. Мөн төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай импортоор орж ирсэн тоног төхөөрөмжийг төсөл дуусах хүртэл гаалийн түр горимд байршуулах зохицуулалтыг хэлэлцээрт мөн тусгалаа. Нэмэлт санхүүжилтийн маань ерөнхий хэлэлцээр гэх юм бол жилийн 1.75 хувийн хүүтэй, үйлчилгээний шимтгэл болон хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл 0.5 хувь, 5 жил үндсэн төлбөр чөлөөлөгдөх нийт 20 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй болно. Тус зээлийн хэлэлцээрийг намрын чуулганд багтааж байгуулах Улсын Их Хурлаар соёрхон батлах нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслийн нэг болох газрын тос боловсруулах үйлдвэрийг барих төслийг бүрэн хэрэгжүүлж төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахад өндөр ач холбогдолтой болоод байна. Төслийн санхүүжилтийн хувьд төлөвлөгөөний дагуу 2027 онд буюу ЕРС 4 зурагдсанаас хойш 36-аас 38 сарын дотор ашиглалтад орохоор ингэж гэрээнд заагдана. Тийм учраас бид үлдсэн 3 жилийн хугацаанд буюу 25, 26, 27 онуудад жил тус бүр 477.1 сая ам.доллар буюу мөнгөн төгрөгөөр бол ойролцоогоор 1.6 их наяд төгрөгийн зардлыг төсөвт тусгаж санхүүжүүлэх шаардлага бий болж байгаа гэсэн хэдий ч манай одоо

баримталж байгаа төсвийн дүрэм бид нар энэ төсвийн дүрэмд ямар ч буруу байхгүй. Гагцхүү энэ удаагийн энэ төсөл маань өөрөө ийм том төсөл. Тэгээд хугацаа нэлээн шахагдаж байгаа учраас жилд гарах зээлийн ашиглалт ийм өндөр байгаа юм аа.

Тийм учраас 2025 оны төсвөөс эхлээд дор хаяж 1.6 их наяд төгрөгийн зээлийн ашиглалтыг нэмж тусгах ийм шаардлагатай болж ирж байна. Гэвч энэ маань энэ жилийн бидний алдагдалгүй төсөв цаашдаа энэ төсвийн хүрээний дунд мэдэгдлээр 2026, 2027 онуудад мөн алдагдалгүй байхаар заасан дүрэм. Эдгээрүүд дээрээ нэг удаагийн хууль гаргах замаар энэ санхүүжилтүүдийг шийдэхээс өөр аргагүй болж байгааг Их Хурлын гишүүддээ эртхэн дуулгаж байя гэж бодлоо. Тэгээд дараагийн бидний шийдвэрлэж өгөх асуудал маань энэ болох нь ээ. Гэхдээ юуны өмнө зээлийн нэмэлт санхүүжилтээ соёрхон батлах нь бидний өнөөдрийн тулгамдсан асуудал болоод байна.

Анхаарал тавьсанд баярлалаа. Мэдээлж дууслаа.

Г.Тэмүүлэн: Зээлийн хэлэлцээрийн асуудлаар бол Эдийн засгийн байнгын хороо хуралдсан байгаа. Ингээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болоод Төсвийн байнгын хороонд хамтарсан хуралдаанд зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ хүргүүлэх учиртай.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Батсүмбэрэл гишүүн танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Л.Батсүмбэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ. Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ. Төсөл санаачилгын зүгээс газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын 4 дүгээр багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг БНЭУ-ын Экспорт Импортын банкнаас санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг өргөн мэдүүлжээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал зээлийн хэмжээ нэмэгдсэн нь төслийн ТЭЗҮ-д хэрхэн нөлөөлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Батболд уг төслийн ажил ямар шалтгааны улмаас удааширсан төслийг хэрэгжүүлж дуусах бодит хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан өмнөх санхүүжилтийг зарцуулсан үйл ажиллагаа өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлууд болон гэрээний төсөлд ТЭЗҮ болон гүйцэтгэх компаниудын мэдээлэл дутуу байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан уг төслийн гүйцэтгэл хэдэн хувьтай байгаа мөнгөн дүнгийн хөрөнгийг зарцуулж дуусаагүй байхад нэмж санхүүжилт авах болсон шалтгаан нөхцөл төслийг гүйцэтгэж дуусахаар төлөвлөсөн бодит хугацаа төсөлд голлох ач холбогдолтой үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэхгүйгээр ямар шалтгааны улмаас бусад барилга байгууламжийг барьсан болон зээлийн үнийн дүнгийн өсөлтийг хөндлөнгийн байгууллагаар шалгуулсан эсэх талаар, Улсын Их Хурлын

гишүүн Бадамсүрэн Газрын тосны үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр тодорхой стратеги байгаа эсэх, Зээлийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг байгуулж ажиллуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг анхны ТЭЗҮ алдаатай хийгдсэн шалтгаан нөхцөл уг зээлийн үнийн дүнгийн өсөлтийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх үед хөндөөгүй шалтгаан, төслийн хүү, хугацаа хожимдож байгаа хариуцлага хүлээх албан тушаалтны талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах хувь хэмжээ, нөөцийн талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батболд төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн хувийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Монгол Улсын талаас гүйцэтгэх үйл ажиллагаа хариуцах этгээдийг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл өмнө байгуулсан гэрээнд заасан хариуцлагын асуудлыг сайтар анхаарах, одоо гэрээ байгуулахдаа мөн зээлийн хүү хүлээх хариуцлагын тооцооллын анхаарах шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн жил болгон гэрээний биелэлтийг дүгнэх биелэгдээгүй тохиолдолд тодорхой хугацаанд хариуцлага хүлээлгэж байх саналыг тус тус хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүнд баярлалаа.

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулттай гишүүд байна уу? гишүүдийн нэрсийг авъя.

Батболд гишүүнээр тасалъя. Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууна.

З.Мэндсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Би энэ зээлийн хэлэлцээрийнхээ өргөтгөлийг нэмж авах гэж байгаа асуудлыг дэмжиж байна аа. Ер нь цаашдаа бид нар дотооддоо шатах тослох материал энэ нефтийн үйлдвэрийг бий болгосноороо хямд гэхээсээ илүүтэй найдвартай хангамжийн асуудлаа шийднэ гэж ойлгож байгаа. Тийм учраас дэмжиж байна. Зүгээр Туваан сайдаас асуух гэж байгаа асуулт юу вэ гэхээр зэрэг үйлдвэр маань ашиглалтад ороход одоо байгаа газрын тос олборлож байгаа компаниудын маань нийлүүлэлт хангаж дийлэх үү? Энэ дээр Уул уурхайн яам нэмж хайгуул судалгаа явуулж байгаа асуудал байгаа юу энэ нөөцөө ер нь хэрхэн харж байгаа юм бэ л гэдэг асуулт байна.

Г.Тэмүүлэн: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Хамтарсан Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа. Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор жилдээ 1.5 сая тонн түүхий тос хэрэглэнэ. Манай улсын хувьд өнгөрсөн 2024 оны гүйцэтгэлээр 552 мянган тонн түүхий тос олборлож экспортод гаргасан. Тэгэхээр зөрүү бол нэг 950 орчим мянган тонн тосны дутагдалтай харагдаж байгаа. Яг бодитойгоороо ийм байгаа 2013, 2014 онуудад бид

нар максимум 1.1 сая тонн түүхий тос олборлож экспортод гаргаж байсан. Энэнээс хойш бас энэ Петрочайна Дачин Тамсаг голлож хөрөнгө оруулалтаа тодорхой хэмжээнд бууруулсны улмаас энэ олборлолт ингээд багасаад явж байгаа. Энэ дээр бол бас дотоодын манай Монгол Улсаас шалтгаалах үндсэн 2, 3 томоохон шалтгаанууд байгаа. Татварын маргаантай асуудал байгаа.

Дээрээс нь тэр орон нутгийн дахиад дээрээс нь бас төрийн бус байгууллагуудын энэ тэр гээд асуудлууд. Данс хаагдсан энэ тэр гээд маш олон хүчин зүйлүүд байгаа. Тэгээд энэ талаар БНХАУ-д Монгол Улсын Ерөнхий сайдыг айлчлах үеэр Си Эн Пи Си компанийн ТУЗ-ийн дарга болон удирдлагын багтай уулзаж энэ асуудлуудыг харилцан шийдвэрлэж, хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, энэ хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж олборлолтоо нэмэгдүүлэх асуудлыг бол ярьсан байгаа. Энэ жилийн хувьд бол бид нар 750 мянган тоннд хүргэх гэсэн энэ асуудлаар асуудлаа тавиад яриа хэлэлцээрийн түвшиндээ явж байгаа гэдгийг хэлье. Мөн Засгийн газрын зүгээс, хамтарсан Засгийн газрын зүгээс Петрочайна Дачин Тамсаг болон Доншин компаниуд олборлолт хийж байгаа.

Дээрээс нь Английн хөрөнгийн биржид бүр бүртгэлтэй Петроматад компани олборлолтоо эхлүүлсэн байгаа. Засгийн газрын зүгээс 6 талбайд хайгуулын талбай зарлаж бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулаад ажиллаж байна. Тэгэхээр манай улсын одоогийн байгаа Петрочайнаийн 19, 21 дүгээр талбай дээр бол геологийн 300 гаран сая тонн нөөцөөс ашиглалтын баталгаат нөөц 41 сая тоо нь тогтоогдсон. Эндээс 10 саяыг бид нар экспортод олборлоод гаргасан. Одоогийн байдлаар бол 31 сая тонны нөөцтэй байгаа. Тэгэхээр нөөцийн хувьд бол боломжтой. Мөн үйлдвэр ашиглалтад орох энэ 36 сарын хугацаанд бид бүхэн энэ олборлолтоо олборлолт хийж байгаа компаниудтайгаа хамтран ажиллаж 1.5 сая тоннд хүрэх бүрэн боломжтой гэж ингэж харж байгаа.

Г.Тэмүүлэн: Заяабал гишүүн асуултаа асууя. Заяабал гишүүн.

Б.Заяабал: Өдрийн мэнд хүргэе ээ. Тэгэхээр энэ нефтийн үйлдвэр бол Монгол Улсад яах аргагүй хэрэгтэй. Стратегийн ач холбогдолтой ийм бүтээгдэхүүний үйлдвэр бол Монгол Улсад зайлшгүй хэрэгтэй байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа. Энэ агуулгаараа манай Их Хурал ч гэсэн бүрэн бүрэлдэхүүнээрээ энийг ч гэсэн энэ зээлийн хэлэлцээрийг ч гэсэн дэмжээд явна гэж ингэж бодож байгаа. Монгол улсад нийтдээ 1.2 сая тонн шатахуун нефть хэрэгтэй энэний үндсэндээ 60 орчим хувийг энэ үйлдвэр ашиглалтад орвол хангах ийм боломжтой гээд ингээд тооцоод үзэхээр зэрэг ямар их стратегийн ач холбогдолтой үйлдвэр болох нь вэ гэдэг нь эндээс тодорхой байгаа юм аа.

Ингээд 2017 оноос хойш эхэлсэн энэ төсөл маань өнөөдөр ингээд 2025 он болоход үндсэндээ 268 орчим сая долларыг нь л ашиглачихсан ашиглалт нөгөө гүйцэтгэл нэг 20 орчим 21.2 хувьтай гэдэг бол үнэхээрийн туйлын хангалтгүй байна л даа. Туйлын хангалтгүй байна. Намын бүлэг дээр өглөө бас энэ дээр нэлээдгүй мэдээлэл сонссон. Одоо ингээд 700 нэмэгдэхээр нийт зээл маань 1.7 сая тэрбум доллар. 1.7 тэрбум доллар болно. Ингээд 268-ыг хасахаар цаана нь 1.5 орчим тэрбум доллар үлдэж байгаа. Энэ жил 300 орчим тэрбум төгрөгийг нь ашиглана гэдэг ийм саналыг бас Сангийн яам руу ирүүлсэн гээд ингэж хэлж байгаа.

Цаана нь дахиад 1.2 үлдэж байгаа. Тэгэхээр үлдэж байгаа 2 жилдээ 3 жилийн дотор ашиглалтад оруулна гээд байгаа учраас үлдэж байгаа цаана нь үлдэж байгаа

2 жилдээ энэ 1.2 их наяд тэрбум долларыг ашиглах ийм шаардлага үүсэж байна л даа. Тэгээд энэнтэй холбоотойгоор би Сангийн яамнаас асуух гээд байгаа юм. Энэ жилийн энэ 300 сая долларыг зарцуулах гэхээр нөгөө нэг зээл тусламжийн чинь энэ лимит нь хүрчээд байгаа. Сая Сангийн сайд энэ дээр тусгайлан бие даасан хууль гаргах ийм болзошгүй байна гэдгийг сая мэдээлэл хэлж өглөө. Тэгэхээр энэ дээр нь юу гэж асуух гэж байна гэхлээр зэрэг энэ төсвөөс гадуур бие даасан хууль гаргана гэсэн үг үү? Энэ чинь Төсвийн зардал тал дээрээ бичигдэж явдаг ийм хянагдаж явдаг ийм зүйл шүү дээ. Сая бол төсвийг алдагдалгүй батална гэдгийн хүрээнд энэ зээлийн ашиглалтаас 700 орчим тэрбум төгрөгийг хасаж Засгийн газраас өргөн барьсан. Энэ дээрээ тодорхой мэдээлэл нэгдүгээрт өгөөч гэж.

Хоёрдугаарт нь энэ татварын асуудал байгаа. Яах аргагүй бид нар түүхий эдийгээ давхар тооцож явах ёстой. Энэ татварын маргааны асуудлуудыг энэ Чайна Энержигийн асуудал явж байгаа энэ үед нь хамтад нь шийдэх боломжгүй юм уу гэдэг дээр энэ салбарын сайд байгаа учраас асуучихъя. 3-д нь энэ шугам хоолойны ажил яваад дуусаж байгаа. Гэтэл үйлдвэр нь 3 жилийн дараа явах гээд байдаг. Шугам хоолойг яагаад ийм өмнө нь хийж ингэж дуусгах ийм шаардлага үүссэн юм бэ гэдэг ийм асуулт.

Дөрөв дэхэд нь энэ гаалийн түр горимоор баахан тоног төхөөрөмж ороод ирчихдэг. Жил жилээр сунгахаар зэрэг төслийн үйл ажиллагаанд хүндрэл учраад байна гээд байгаа. Нийт хэчнээн тоног төхөөрөмж орж ирээд ямар хүндрэл учраад байгаа юм бэ гэдэгтэй холбоотой ингээд. Нэг юм хийх гээд бүх хуулиудад өөрчлөлт оруулаад дэмжлэг үзүүлээд явдаг ийм шаардлага байхгүй байх л даа гэж ингэж харж байгаа юм. Тэр агуулгаар асууж байна аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайд. Номер 2.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Үнэхээр одоо Их Хурал маань соёрхон баталчихвал бид нарын дараагийн сорил яг тэр л болчхоод байна л даа. Одоо яг үнэнтэйгээ л тулж байна гэсэн үг. Одоо байгаа бидний төсвийн дүрэм бол муу юм байхгүй. Бид өөрсдөө уул уурхайгаас бас хамааралтай ийм эдийн засагтай учраас аль болох энэ савлагааг нь хязгаарласан ийм дүрэмтэй явдаг. Энэ нөхцөлд гэсэн хэдий ч энэ төсөл маань өөрөө их том төсөл, бага төсөл биш. Энэ чинь бараг Ораногийн хэмжээний хөрөнгө оруулалт шүү дээ. Тэгсэн мөртөө энэ ашиглалтад оруулах хугацаа маань маш ийм давчуу учраас тэгэхгүй бол хэрвээ энийг сунгах юм бол төсөвт өртөг нь нэмэгдэх, төслийн үр өгөөж нь буурах маш өндөр эрсдэлтэй учраас 38 сарын дотор барьж ашиглалтад оруулах 1.7 тэрбум долларыг ашиглаж дуусах ийм сорилт гарч ирж байгаа юм.

Тэгэхээр яалт ч байхгүй л одоо бид нарын нэг удаагийн хууль гаргадаг уу, эсвэл өөр ямар хувилбар байж болох вэ сайн жишээ юу байна? Яах вэ нэг удаагийн хууль гэдэг нь бид нар урьд нь ийм туршлага манайд төсвийн хуульд байсан юм байна лээ. Тэгэхээр тэр жишгээр ингээд шийдээд зөвхөн энэ долларын эх үүсвэртэй энэ зээлийн ашиглалт дээр нэг удаагийн хууль гаргаад хугацаатай энэ төсөл хийж дуустал зөвхөн энэ төсөлд зориулж зээлийн хязгаарлалтад тооцохгүй байх ийм зохицуулалт хийж байж энэ төслөө хэдүүлээ амжилттай дуусгаж ашиглалтад оруулах л ийм л боломж байгаа юм.

Тэгэхээр энэ төслийн ач холбогдол бол маш өндөр байгаа. Энийг надаар хэлүүлэлтгүй гишүүд маань маш сайн ойлгож байгаад баяртай байна. 1.7 тэрбум

долларын төсөвт өртөг. Гэтэл энэ ашиглалтад ороод эхлэх юм бол энэ чинь жилдээ бараг дор хаяж тэрбум 200-аас тэрбум 500 сая долларын бүтээгдэхүүний гадаа хийх гадагшаа хийдэг байсан төлбөрийг бид нар авч үлдэх ийм боломж гарч ирэх байхгүй юу. Тэгэхээр төлбөрийн тэнцэл дээр юун 1 удаагийн 1.7 битгий хэл жил бүр дунджаар 1.5 тэрбум доллар хүртэл ийм ашигтай байлгах нөхцөлийг бүрдүүлэх ийм өндөр өгөөжтэй төсөл учраас ийм зохицуулалт бол би хийж болно гэж харж байгаа юм. Ач холбогдолтой нь харьцуулах юм бол.

Петро чайнатай холбоотой энэ маргааны асуудал бол хамгийн зовлонг нь мэдэх хүн бол манай Заябал гишүүн өөрөө байгаа. Тэгээд тэр талаар санаа зовж байгаа нь аргагүй ээ. Тэгэхдээ бид нар бас нөгөө суурь зарчмаа алдахгүйн тулд энэ дээр нэлээн аль аль талаа хараад ажиллаж байна. Хууль зүйн яаман дээр энэ талын хуулийн зохицуулалт төсөл хийгдэж байгаа. Удахгүй ойрын хугацааны Засгийн газрын хуралдаанаар ороод шийдэл нь гарах байх. Тэр үед танд би тодорхой мэдээлэл гарцууд ийм юман дээр тогтлоо гэдгийг нь танилцуулъя. Ер нь өнөөдрийг хүртэл манай Монгол Улсын татварын байгууллага бол яг хууль журмынхаа хүрээнд петрочайна ч бай Оюу Толгой ч бай бүх төслүүд дээр бол яг хууль журмынхаа хүрээнд гүйцэтгэх байгууллагын хувьд бол яах аргагүй хууль талдаа маш сайн үр дүнтэй ажилласан байгаа.

Цаашдаа бол яах вэ зүгээр төслүүд дээр тусгайлан олон улсын гэрээгээр баталгаажиж байгаа энэ томоохон ач холбогдол бүхий стратегийн төслүүд дээрээ яаж явах вэ гэдгийг Засгийн газрын хувьд нэг шийдэл гаргахаар цаашдаа маргаан дахиж гарахгүй байхаар ийм байдлыг гарц гаргахаар ажиллаж байгаа гэдэг ерөнхий мэдээлэл өгье дөө.

Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Бүгдэд нь ардчилсан Үндсэн хуулийн ойн өдрийн мэндийг хүргэе ээ. Энэ газрын тосны үйлдвэр маань уул нь бол 2023, 2024 онд ашиглалтад орчихно л гэж зээл авч байсан л даа. Миний санахын. Тэгээд 1 тэрбум 200 гаруй сая доллар бол хангалттай их мөнгө өө. Ингээд оруулчихна гэж яриад л ингээд зээл аваад л ажилласан. Тэгээд өнөөдөр энэ бүтэлгүйтлээ. Одоо тэр мега төслүүд яаж явах юм. Үлгэр жишээ энэ л болчихоод байна л даа. Дарханы замаа бид нар яаж хийлээ. Ард түмний санаанд үлдсэн л дээ. Тэгээд одоо энэ хугацаанд нь хийж чадаагүй үнэ өртөг нь ингэж өссөн тиймээ. Энэнтэй одоо хариуцлага тооцсон юм байгаа юм уу? Уг нь аудит оруулаад зохих хүмүүст нь хариуцлага тооцоод тэгснийхээ дараа бид нар энэ зээлийг ярих хэрэгтэй гэж бодоод байна.

Тэгэхгүй бол энэ явдал чинь ахиад давтагдана аа. Тэрбум 700 сая доллар гэдэг бол маш их мөнгө. Тэгээд энэ хийсэн ажлыг нь харахаар бол хэрэв хувийн хэвшил хийсэн бол ингэж тэр туслах байшин барилгаа бол хийхгүй. Тэрийгээ 100 хувь хийчихсэн байна шүү дээ. 260 сая доллардоо. Үйлдвэрээ босгоно. Гэтэл үйлдвэр тоног төхөөрөмж байна. Наймхан хувь. Тэр 8 хувьд нь юу хийчихсэн юм. Тэгээд газрын тосны түүхий эдийн нөөц байхгүй. Тэгээд баахан тэндээс нь газрын тос гарах ч юм уу, үгүй ч юм уу юу ч мэдэхгүй газар руу баахан тийм урт юу аваачаад татаад тавьчихсан. Эд нар чинь ямар учиртай юм бэ? Ингэж хүйтэн сэтгэлээр хандаж болохгүй шүү дээ та нар. Тэгээд хэлээд байгаа шүү дээ. Энэ үйлдвэр чинь ашиглалтад орчихсон байсан бол өнөөдөр бид нефть шатахуунаар бид нар гацахгүй л байлаа. Бас л алдагдсан боломжууд. Энийг хийгээд чадах үйлдвэрлээд явж байсан энэ туршлагатай өөрсдийнхөө хувийн ААН-үүдийг нийлүүлээд ХК

болгоод тэд нарт нь зээл авч өгөөд бусад улс орнууд ингэж л ажилладаг. Гэтэл төр хийнэ, төрийн компани байгуулна. Тэгээд нэг дампуурсан юм болдог. Одоо яаж байна вэ? Аягүй л бол үнэхээр та нар чадах ёстой. Ард түмэн саналаа өгсөн. Сонгуулиар хийсэн. Үндсэн хуулийнхаа дагуу 68 суудалтай Ардын нам энийгээ хариуцлагаа хүлээгээд дуустал хийх ёстой. Гэтэл үгүй байна. Одоо сөрөг хүчин хийгээд байж байх ёстой манай Туваан тэнд суугаад л. Дараа нь одоо яах юм тэгээд Туваантай хариуцлага тооцож байна гээд л баахан хүмүүс шоронд явуулаад л бид нар адилхан муу муухай юм хамтдаа хийсэн гэх юм уу. Эсвэл яах юм?

Газрын тосны үйлдвэрийн даргыг нь анх эхлээд Ардын намын үед ч гэсэн одоо АН-ын нэртэй гишүүний нөхөр нь хийж байсан. Тэгэхээр эд нар хамт хариуцлага хүлээх ёстой гэх юм уу? Ийм байж болохгүй ээ та нар. Бид нар зээл авч л байдаг юм, мөнгө авч л байдаг юм. Эцэст нь бид нар төлөхгүй, ард түмэн төлдөг юм.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. 3 номерт Туваан сайд.

Ц.Туваан: Ганбат гишүүний асуултад хариулъя аа. Энэ 2017 онд энэ Энэтхэгийн Засгийн газраас олгох 1 тэрбум долларын зээлийн асуудал яригдаад үүнийг ямар төсөлд зарцуулах вэ гэдэг шийдвэр гараад газрын тос боловсруулах үйлдвэр барья гэдэг шийдвэр гараад ТЭЗҮ-ийг нь баталсан байгаа. Тэгээд энэ ТЭЗҮ нь бол 1 тэрбум 236 сая доллароор ТЭЗҮ нь анх батлагдаж гарч ирсэн. Ингээд 2019 оны 6 сараас энэ үйл ажиллагаа яг газар дээрээ эхлэх шаваа тавиад энэ үйл ажиллагаа эхэлсэн гэдгийг хэлье. Энэ хооронд бол мэдээж ганц Монгол Улс гэлтгүй дэлхий даяар ковид цар тахлын хүндрэл гарч ирсэн энэнтэй холбоотой бас цаг хугацааны хувьд хойшилсон тал бий.

Дээрээс нь энэ бол ганцхан Монголын талаас шалтгаалах ийм төсөл биш. Гадаад улсын Засгийн газар тэр дундаа Энэтхэгийн Засгийн газар, Эксим банк, Энэтхэгийн бусад компаниуд гээд нэлээн олон гаднын хүчин зүйлүүдээс болж тендер зарлах, тендерт оролцох компани гэх мэтийн зүйлүүдээс бас нэлээн шалтгаалсан. Хамгийн сүүлийн энэ жишээ өнөөдрийн орж ирж байгаа соёрхон батлуулах гэж байгаа зээл гэхэд л хүсэлт тавьснаас хойш 1.6 жилийн дараа зөвшөөрсөн хүсэлт ирээд одоо оруулж ирж байх жишээтэй.

Тэгэхээр иймэрхүү байдлуудаас болж энэ одоо төслийн явц бас удааширсан тал байгаа. Энэ ажил ажлуудыг бол ЕРС буюу энэ инженерчлэл барилга угсралт худалдан авалтын байдлаар 4 төсөл болгож хуваасан. ЕРС 1, 2, 3, 4 гээд. Энэ 4 төсөлдөө ЕРС-1-ийн төсөл 100 хувь, 2 нь 22.7 хувьтай, ЕРС-3 нь 13 хувьтай, ЕРС 4-ийн ажил нь одоогоор ингээд эхлээгүй ийм гүйцэтгэлтэй буюу санхүүжилтийнх нь хувиар авч үзвэл нэг 23.5 хувийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй явж байгаа ийм төсөл байгаа. Мөн одоо энэ төсөл дээр газрын тос боловсруулах үйлдвэр нь Эрдэнэс Монгол нэгдлийн харьяанд яамаар бол ЗГХЭГ-т байгаа.

Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн асуудлаар ажлын хэсэг байгуулаад Мөнхбаясгалан гишүүн ахлаад ажиллаж байгаа. Засгийн газраас энэ үйлдвэр барих ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийг миний бие ахлаад ингээд ажиллаж байгаа гэсэн хариултыг өгье өө.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Асуусан асуултад нэг тодорхой хариулт алга аа. Тов тодорхой асуулт тавьж байгаа. Хэн хариуцлага хүлээх юм? Хэзээ орсон юм. Яагаад ороогүй юм гээд ингээд асууж байхад чинь тэрэнд тодорхой хариулт өгч байгаа юм алга. Ер нь сөргө хүчингүй бол 8 жил ажилласны л үр дүн шүү дээ энэ чинь. Тэгээд сөрөг хүчингүй байна гэж байхгүй л дээ. Хэрвээ ардчилсан улс юм бол. Тэрийг чинь ард түмэн орлоод гудамжинд гараад ирчихлээ. Энэ өвлийн хүйтэнд. Хавараас бүүр ч одоо ихсэх байх.

Тэгэхээр энэ жонхуурсан Засгийн газарт олон түмэн итгэхээ байчихсан байна шүү дээ. Тэр Үндсэн хуулийнхаа дагуу олонх нь ажлаа хийгээд энэ олон 126-тай пролламентад 48 хүнийг нь энэ алдаа дутагдлыг нь хэлж өгч засаж залруулагдтал байхгүй. Энийг бол өрийн хавх гэж үзэж болно. Өрийн хавханд л бид нар улам суугаад байна шүү дээ. Урд талд нь хариуцлага тооцохгүй. Энэ ард түмний мөнгөний араас нэхэхгүй ингээд яваад байхаар энэ чинь ашиг.

Г.Тэмүүлэн: 2 номер Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ганбат гишүүний асуултад нэг нэмэлт мэдээлэл өгье өө. Тэр цаг хугацаатай холбоотой асуулт удаа дараа асуулаа. 2017 онд бол төсөл тодорхойгүй байсан. Энэтхэгийн Засгийн газраас 1 тэрбум долларын зээл өгье өө л гэсэн. 2018 онд төсөл тодорхой болсон. ТЭЗҮ батлагдсан тэрбум 286 сая доллар. Ингээд 2019 онд ЕРС 1-ээсээ эхэлсэн. Өөрөөр хэлбэл энэ нийгмийн зориулалттай ийм барилга байгууламжууд байсан, байгаа. Ингээд ЕРС 2, 3 руугаа орох гэтэл 2020 он гээд ковидтой залгасан. 2020, 2021 онуудад төсөл бүр таг зогссон. Энэтхэгийн талаас ерөөсөө ямар ч гүйцэтгэгч наашаа ирэх боломж байхгүй ингээд зогссон. Ингээд ковидтойгоо мунгинаж байтал 2019, 2020, 2021, 2022, 2023 гээд 4 дэх жил дээрээ нөгөө 2019 онд эхлүүлсэн тоолуурын зээлийн маань үндсэн төлбөрийн хугацаа нь болчихсон. Нэг ч төсөл эхлүүлж чадаагүй байтал. 100 сая долларын л ашиглалт гарчихсан байтал нөгөө талдаа 64 сая.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд минут нэмж өгье.

Б.Жавхлан: Үндсэн зээлийн төлбөр эхэлж байсан. Ингээд зээлийн ерөнхий нөхцөл дээр бид нар өөрчлөлт оруулахгүй бол энэ цаашаагаа энэ төслөөр явах 90-ерөөсөө ямар ч боломжгүй болсон. Ингээд 2023 оны 2 сараас 2023 оны 8 сар хүртэл 6 сарын хугацаанд Энэтхэгийн талтай хэлэлцээр хийгээд энэ төслийн санхүүжилтийг нь байгууламж бүрээр нь ЕРС 1, 2, 3, 4-ийг хоорондоо хамааралгүйгээр бие биеийгээ хүлээхгүйгээр зэрэг 4 фронт дээр санхүүжүүлж явахаар нэгдүгээрт.

Хоёрдугаарт тулчихсан байсан үндсэн төлбөрүүдийг нь 7 жилийн хугацаатайгаар 2030 он хүртэл ингэж сунгаж чадсан байгаа. Ингэснээр эргэн төлөгддөг цаг хугацааны ийм хайчнаас гарч чадсан байгаа. Тэгэхээр цаг хугацааны алдагдал гэхээсээ илүүтэйгээр бид нар дараагийн цаг хугацаандаа хугацааны хувьд үүсэж болзошгүй энэ эрсдэлийг бол холдуулж чадсан. Тэгээд ч төсөв дээр аль болох дарамт багатайгаар энэ өөрөө ч дамжууланан зээл.

Ингээд одоо төслийг цаашаа амжилттай үргэлжлүүлэх боломж бүрдсэн гэсэн үг. Өнөөдрийн энэ яригдаж байгаа жишээний нэмэгдэл.

Г.Тэмүүлэн: Нэмээд хариулах уу? 2 номер Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм. Тэгэхээр өнөөдөр яригдаж байгаа энэ 464 сая долларын нэмэлт санхүүжилтийг бол 2023 оны 9 сард УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр ТЭЗҮ нь эцэслэж батлагдаад тэр даруйд нь Хятад Энэтхэгийн Эксим банканд хүсэлтээ илгээгээд сая өнгөрсөн оны 12 сарын 9-нд бид нарт эцсийн хариу ирээд одоо ингээд шат дараатай процесс нь явж байна.

Г.Тэмүүлэн: Ганхуяг гишүүн асуулт асууя.

Д.Ганхуяг: Би энэ асуултыг дахиад л тавих хэрэгтэй болчихоод байгаа юм л даа. Нөгөө хариу байхгүй. Манай Туваан сайд сайн ажиллаж байгаа. Би ерөөсөө та хувь хүн дээрээ битгий ерөөсөө яагаарай. Ажлаа ч аваад удаагүй байна. Галтай ч олон хуулийг сая авч гарлаа. Гэхдээ энэ төсөл бол яалт ч үгүй ярихаас өөр арга алга. 8 жил шүү дээ 8 жил. Тэгээд 1.2-хон тэрбум байсан төсөл өнөөдөр 1.7 болчихсон явж байгаа байхгүй юу. Тэр өмнөх алдаатай ТЭЗҮ дээр нь, энэ хугацаа алдсан асуудал дээр нь. Тэгээд тэр оновчгүй хөрөнгө оруулалт хийгээд эрэмбэлээд явж байгаа асуудал дээр нь хэн ч хариуцлага хүлээгээгүй. Тэгсэн мөртөө та нар энэ захирлыгаа аягүй мундаг захирал гээд л яриад суугаад байгаа юм. Яах вэ энэ дээр тэр бол зүгээр гүйцэтгэх захирал хариуцлага хүлээх асуудал биш ээ. Энэ дээр улс төрийн хариуцлага хүлээх ёстой юм.

Гэхдээ өнөөдөр таны цаг тоолуур эхлэх гэж байгаа гэсэн үг шүү. Засгийн газар дээр шийдвэр гаргах ёстой яг энэ төслийг яг хэн хариуцах юм бэ гэдэг улс төрийн энэ хариуцлагыг 38 сарын дараа энэ төсөл одоо энэ төсөөлж байгаа төсөвтөө баригдаж дуусах, мөн хугацаандаа дуусгасан энэ 2 асуудал дээр Засгийн газраас хэн нэгэн сайд заавал ч үгүй хариуцлага хүлээх ёстой шүү. Тэрнээс биш ингээд л орж ирэх болгонд нь хугацааг нь нэмж өгөөд л мөнгийг нь нэмж өгөөд л 20-хон хувийн гүйцэтгэлтэй байж бид нар ингээд л зээлийн үндсэн төлбөрийг төлөөд эхэлчихсэн явж байна шүү дээ. Зээлийн хүүг нь төлөөд л явж байна шүү дээ. Үгүй тэгээд ингэж болох уу? 7 жилийн дотор өөрийгөө нөхнө гэж байсан үйлдвэр арван хэдэн жил болчихсон явж байна. 38 сарын дараа энэ төсөл дуусахгүй бол наад ярьж байгаа санхүүжилтийн дүн чинь дахиад нэмэгдэнэ. Утаа болно шүү. Энэ юун Дархан цаашаа болно шүү.

Тэгээд би энэ асуулт дээр дахиад л хариу авах гээд байгаа юм. Та энэ дээр шийдвэрээ гаргаж өг өө. Нэг бол бид нар Их Хурлын тогтоолоор та нар дээр үүрэгжүүлье. Тэгэхгүй бол одоо ингээд ярингуут Хэрэг эрхлэх газрын дарга ч хариуцлага хүлээх гээд байгаа юм шиг, эсвэл одоо тэр Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр байгуулагдсан ажлын хэсгийн дарга ч хариуцлага хүлээх гээд байгаа юм шиг. Эсвэл одоо Туваан сайд ч хариуцлага хүлээх гээд байгаа юм шиг. Ингээд нэг ийм дунд нь аваачаад л хаячхаж байгаа юм. Тэгсэн мөртөө өнөөдөр та нар бүх асуудлаа шийдүүлье гээд л орж ирж байгаа шүү дээ. Тэгээд энэ асуудлаа шийдэхээс гадна одоо бид нар төсвийн тодотголын асуудал зайлшгүй яригдаж таарна. Энэ төслөөс гадна өөр ер нь гацаанд орсон гадаадын зээлтэй холбоотой өөр ямар төсөл байгаа вэ? Тэр мэрийгээ ер нь эртхэн шиг яриад явж байвал яасан юм бэ? Жавхлан сайд аа? Энэ 2 асуултын хариугаа авчихъя.

Г.Тэмүүлэн: Туваан сайд асуултад хариулъя. 3 номер.

Ц.Туваан: Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн асуудал бол хувьцаа эзэмшигч нь Эрдэнэс Монгол нэгдэл. Эрдэнэс Монгол нэгдэл ЗГХЭГ-ын харьяанд

байгаа. Тэгэхээр одоо өмнө нь бол УУХҮЯ бол энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьцаа эзэмшигч байсан. 2023 оны 3 сард Эрдэнэс Монгол нэгдлийн харьяа руу очсон. Мэдээж бас хариуцлагын асуудал гээд маш олон гишүүд ярьж байгаа энэ бол зүйтэй.

Тэгэхээр энэ одоо хариуцлага дээр бол бас эргээд яг тодорхой. Дараа нь энэ зээлийн хэлэлцээр соёрхон батлахаар дахиж орж ирнэ. Энэ дээр засаг дээр яриад энэ талаар хариуцлагын асуудал нь энэ гэрээ хэлэлцээр бусад хууль тогтоомжид яаж байдаг талаар мэдээд хариулъя. Өөр чинь нэг асуулт нь юу байлаа?

Нөгөө төсвийн тодотголд нь хариулчихъя.

Г.Тэмүүлэн: 2 номер Жавхлан.

Б.Жавхлан: Ганхуяг гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье өө.

14 мега төслийн маань ойрын хугацаанд нэг бодитой яг үр өгөөжөө өгөх ойрын хугацаанд шүү, ойрын хугацаанд энэ төслөө бүгдээрээ тал талаас нь асуудлуудыг нь шийдээд явбал одоо яг энэ нэг төлөвлөсөн хугацаандаа бол орчихно болов уу л гэж ингэж харж байгаа. Одоо бол нэг их айхтар том нь саад би гарахгүй болов уу гэж ингэж найдаж байна. Тийм учраас яах вэ одоогийн дараагийн сорилт бол яах аргагүй бид энэ зээлийн ашиглалтыг энэ 3 жилийн хугацаанд их өндөр шаардлагатай хэмжээнд нь төсөвтөө багтаах л ийм л асуудал үлдээд байгаа юм. Үлдэх юм байгаа юм.

Тэгэхээр энийг одоо макро бусад агрегатууд дээр янз бүрийн өөр эрсдэл учруулахгүйгээр энэ маань өөрөө ер нь яах вэ зээл гэдэг маань боловсролын салбарын ч гэдэг юм уу бусад эрүүл мэндийн салбарын урсгал зардлаас шал өөр. Энэ өөрөө доллароо барьж орж ирж байгаа төсөл. Долларын эх үүсвэртэй. Тийм учраас төлбөрийн тэнцэл дээр бол урсгал тэнцэл дээр бол ямар нэг алдагдал нэмэлт дарамт үүсгэхгүй. Тийм учраас нэг удаагийн өмнө гаргаж байсан ийм зохицуулалт ийм жишгээр ингээд явах нь бол харагдаж байгаа хамгийн зөв хувилбар болов уу л гэж ингэж харж байгаа. Гэхдээ ямар ч байсан өнөөдөр энэ 7 хоногт ингээд шат дараатайгаа хэлэлцээд дуусах юм бол соёрхон баталчих юм бол энүүнийхээ дараагийн асуудал руугаа шийдэл гаргах дээр бүгдээрээ хамтарч ажиллая гэж ингэж харж байна.

Г.Тэмүүлэн: Батболд гишүүн, асуулт асууя.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Ганц хоёр зүйл асуучихъя. Энэ ер нь 30 хувь орчим нэмэгдүүлэх гээд ороод ирлээ л дээ. Тэгэхээр энэ нэг төгрөгийн ханшийн зөрөө бараг бодоод байгаа юм шиг л юм ойлгогдоод байх юм надад.

Тухайн үед гэрээ байгуулж байхдаа 2600, 2700 байсан доллар одоо нэг 3400 болчихоор нь тэрний зөрөө нь 30 орчим хувь ч юм уу. Ийм хачин юм орж ирээд байгаа юм биш байгаа гэдэг зүгээр л нэг тийм бодол төрөөд байна. Зүгээр энэ нэг ЕРС 2, 3 гээд энэ төслүүд дээр нэмэлт хөрөнгө оруулалт шат шаардлагатай болчихоод байгаа гээд байна. Тэгэхээр энэ чинь нөгөө Мэйл гээд нэг ганц компанитай байгуулсан гэрээнүүд байна. Тэгээд энэ чинь 2022 оны 10 сард үнэ бууруулах хэлэлцээ хийгээд одоогийн байгаа үнэ дээрээ бараг л хийсэн юм байна л даа. Энэ чинь бараг хоёрхон жилийн өмнө шүү дээ. Тэгэхээр 2 жилийн дотор үйлдвэрээ

тэртээ тэргүй барьж дуусахгүй нь тодорхой. Тэгээд үйлдвэрлэлийнхээ явцад энэ улсууд чинь ингээд 30 хувиар үнэ нэмье гээд ороод ирдэг юм уу яадаг юм гэдэг нэг ийм сонин асуудал гараад байна л даа. Тэгээд одоо тэр нэг Канадын нэг компани байх шиг байна. Энэ зөвлөх үйлчилгээ юм уу, инженер нь зөвлөхөөр юм уу. Кинетикс технологи гээд.

Тэгэхээр энэ компани чинь бас ямархуу дүгнэлт энэ нэмж авч байгаа хөрөнгө шаардлагатай гэж үздэг юм уу, үздэггүй юм уу? Энэ захиалагчийн инженер гээд нэг компани байна шүү дээ. Эд нар ер нь ямар дүгнэлт өгсөн байдаг юм бэ? Тэгээд бид нар ууланд нэг доллароор хийсэн гэрээ доллароор хийгдэж байгаа ажлууд л яриад байдаг. Тэгээд 2, 3 жил болохоороо л тэр чинь 30 хувь нэмэгдүүлнэ гээд ороод ирэх юм. Энэ ямар учиртай байгаад байдаг юм. Гадаадын зах зээл дээр яг энэ тоног төхөөрөмж, энэ хийгдэж байгаа шаардлагатай тоног төхөөрөмжүүд чинь ингээд 30 хувиар яг үнэхээр өсчөөд байгаа юм уу үгүй юу гэдгээ нэг тэрийг л нэг тодорхой болгомоор байна.

Г.Тэмүүлэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Туваан сайд 3 номер.

Ц.Туваан: Батболд гишүүний асуултад хариулъя аа. Энэ 34 хувийн өсөлт буюу 1 тэрбум 236 сая саяыг 1.7 тэрбум доллар болгож байгаа асуудал нь бол 34 хувийн өсөлт байгаа. Энэ бол тийм төгрөгийн ханшийн зөрөө бол биш. Энэ бол 2018 онд хийсэн ТЭЗҮ дээр 2023 оны 9 сард ТЭЗҮ-ийн тодотгол хийгээд Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хийгээд, тогтоол гаргаад, дүгнэлт гаргаад ингээд ирүүлсэн асуудал байгаа. Энэ ТЭЗҮ дотор нь бол нэлээн олон асуудлуудыг оруулж тооцооллыг хийсэн. Мэдээж одоо бас хэлэхээс өөр аргагүй нэг шалтгаан бол энэ цар тахлын үеийн цар тахлын дараа энэ дэлхийн зах зах зээл дээрх тоног төхөөрөмжийн үнийн өсөлт гэдэг бол гол нөлөөллийг үзүүлж байгаа.

Дээрээс нь бас манай зүгээс энэ онгоцны түлшийг 40 мянган тонноор, авто бензинийг 60 мянган тонноор нэмэгдүүлэх асуудлыг энэ ТЭЗҮ дээр нэмж оруулж өгсөн. Үүнтэй холбоотой тоног төхөөрөмжийн зардал мөн агуулах савын зардлууд гэх мэт томоохоноос нь дурдвал ийм зардлуудын нэмэгдлийг бас ярьж байгаа гэж хэлье. Түрүүний таны ярьсан компани бол Канадынх биш Италийн компани байх. Кэйти гэдэг компани байгаа. Энэ одоо үйлдвэр барих ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт хийсэн ийм компани байгаа юм аа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн, асуулт асууна. Хосбаяр гишүүний микрофоныг өгье.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Бид нар өглөө бүлгийн хурал дээр бас 2, 3 асуултдаа хариулт авчихсан. Тэгээд тэр Сүхбаатар аймгийн нутгаар дамжаад Дорнод аймгаас татаж байгаа түүхий газрын тос татах хоолой маань ажил нь хэдэн хувьтай явж байгаа юм бэ? Тэр Эрдэнэс Монголоос санхүүжүүлж байгаа гээд байгаа тэрний төсөвт өртөг мөртөг нь ер нь хэдэн хувьтай байгаа юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь энэ бид нар ер нь энэ гадаадын зээл тусламжийн үр ашиг, цаг хугацаа, тал дээр нэлээн анхаарахгүй бол энэ газрын тосны энэ төслөөс гадна 10 аймагт хэрэгжиж байгаа дулааны станц гээд нэг дампуурчихсан төсөл байгаа. Бас

Солонгосын Засгийн газрын 500 сая доллароор аль 10 хэдэн жилийн өмнө Солонгосын эмэгтэй Ерөнхийлөгчийн үед анх яригдаж хэлэлцээр хийгдсэн төсөл. Бас л манай Өвөрхангай аймаг, Баянхонгор аймаг дээр ингээд нэг сирийсэн юм дахиад 2.5 жилийн дараа дуусна гэж байдаг. Дахиад баахан үнийн өсөлт дахиад төсөвт өртгийн тухай асуудлууд ингээд яриад байж байгаа ийм төсөл байна аа. Тэгээд энэ газрын тос энэ дулааны станцын төслийг ажиглахад нэг юм их төстэй харагдаад байгаа юм. Эхлээд ингээд нэг ковид руу хамаг буруугаа чихээд байгаа юм. Ковид цар тахлаас болоод юмны үнэ өсөөд ажил удааширсан гээд. Тэгээд сүүлдээ төсөвт өртгөө нэмүүлдэг. Тэгж байснаа одоо тэгээд яг ингээд нэг цаг хугацааны хайчинд оруулж ирээд одоо ЭХЯ-ныхны өгсөн мэдээллээр намар 10 аймгийн дулааны станцын ажил гэрээг нь бараг цуцалж байгаа Солонгосын компанийг болиулж байгаа өөрсдөө хийчхэж болохоор юм ярьж байсан чинь сая оны төгсгөлд гэрээг нь сунгаж байгаа. Солонгосын компани нь үргэлжлүүлээд дуусгана гэсэн ийм юм ярьсан.

Тэгэхээр энэ дээр ер нь энэ гадаадын зээл тусламжаар хийгдэж байгаа ажлууд яагаад яг ийм адилхан загвараар ингээд төсөвт өртөг нь өсөөд ковид руу хамаг буруугаа чихээд тэгээд Монголчууд хийж чадахгүй юм шиг бид нарыг ингээд нэг шахаанд оруулаад л одоо л энийг шийдэхгүй бол энэ төсөл зогслоо барилаа гээд ийм ийм юм руу явуулаад байдаг юм бэ? Энэ дээр ер нь ямар шалтгаан юм байдаг юм? Бид нараас үнэхээр шалтгаалсан ийм юмнууд бас байдаг юм уу? Энэ тал дээр бас Эрчим хүчний сайд бас тэр нэг станцтай холбоотой юман дээр нэг мэдээлэл өгөөч гэж хэлэх гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Туваан сайд эхлээд хариулъя. Дараа нь Чойжилсүрэн сайд. 3 номер.

Ц.Туваан: Энэ мэдээж Дорноговь аймгийн нутагт буюу Алтанширээ сумын нутагт баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэр маань түүхий тосны олборлолт хийж байгаа гол олборлолт хийж байгаа компани 2-ын хооронд 530 км байгаа. Энд бол тэр авчрах асуудал яригдаж байгаа. Тэгээд түүхий тосыг бол дэлхийн практикт бол шугам хоолойгоор далайд гарцтай орны хувьд далайн тээврээр явуулдаг. Төмөр зам болон авто тээврээр тээвэрлэдэггүй ийм зүйл байгаа. Тэгэхээр энэ шугам хоолойн асуудал бол 530 км урттай хоолойн асуудал 2020 онд Засгийн газар дээр шийдвэр гараад тендер нь зарлагдаад БНХАУ-ын Норинко гэдэг компани шалгараад 380 орчим сая долларын тендерт шалгараад үйл ажиллагаа явуулж байгаа. Үйл ажиллагаа яг өнөөдөр бол 82 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа.

Түрүүн бас Заяабал гишүүний асуултад гарч байсан. Тэгээд энэ яг цаг хугацаандаа энэ төсөл нь хэрэгжээд явж байгаа. Ер нь бол энэ тээвэрлэх хоолойн асуудал бол яг энэ үйлдвэр барихаас үйлдвэр ашиглалтад орох хугацаанаас нэг 8 сар орчмын өмнө ашиглалтад орсон байх гэдэг ийм шаардлагатай. Тэгээд үлдсэн ажлууд дээр ихэнх нь энэ шугам хоолойг булах, дээрээс нь замд нь тосыг халааж шахах 4 дэд бүтцийн станцын ажлууд нь хийгдээгүй хийгдээгүй үлдсэн явж байгаа гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: 2 дахь асуулт дээр Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье 10 аймгийн дулааны станц төслийн талаар та бүхэн Хасбаяр гишүүн асуух шиг боллоо тодруулга өгье өө. Энэ 10 аймгийн дулааны станц төсөл маань нийт өртөг нь 10 аймгаа оруулахаар

148 сая долларын төсөвт өртөгтэй ийм төсөл байсан. Энэнээс 1, 2, 3 дугаар багцаар 9 аймгуудын төсөл зарлагдаад буюу Солонгос улсын компани энэ тендерт шалгараад ялсан юм байна лээ. 2021 онд зарласан. Түүнээс хойш Эрчим хүчний яаманд үнийг нэмэгдүүлэх шаардлагатай байна гээд эхний удаа бол 64 сая доллароор нэмэгдүүлье гэдэг ийм хүсэлт ирсэн. Энэ үндэслэлгүй байна гэдэг ийм зүйлээр буцаасан. Дахиад 39 сая доллароор нэмэгдүүлье гэдэг ийм санал ирсэн үгүй гэсэн. Хамгийн сүүлийн мэдээллээр бид нар 2024 оны 11 сарын эхээр байх гэрээ цуцлах мэдэгдлийг Солонгосын талд хүргүүлсэн. Солонгосын талаас ерөнхий гүйцэтгэх захирал нь ирж уулзсан. Элчин сайдын хамт. Ингээд сүүлийн тохиролцоогоор бол тэр магадалшгүй ажил дотор нь байгаа. 11.5 сая доллароор нэмэгдүүлбэл аль аль талаасаа энэ төслийг цаашаа үргэлжлүүлж болох юм байна гэдэг ийм ойлголцолд хүрээд 2026 оны 5 сарын 31-ний өдөр хүртэл гэрээг сунгасан байгаа.

Одоо Эрчим хүчний хөгжлийн үндэсний төв дээр энэ 11.5 сая доллартай тэнцэх хэмжээний өсөлт гарсан уу үгүй юу гэдгийг байцаагчийн дүгнэлт гараад ойрын ирээдүйд ЭХЯ төслийн нэгжид ирүүлэх байх. Энэний дараа бид нар Эксим банканд мэдэгдэнэ. Монгол Улсын Сангийн ямаар дамжуулаад Сангийн сайд зөвшөөрөөд энийг дэмжүүлэх юм бол 11.5 орчим сая доллароор төслийн өртөг нэмэгдэх байх. Ийм л нөхцөл байдалтай байгаа юм 9 аймгийнх нь тухайд.

10 дахь аймаг Архангай аймгийн тухайд бол дулааны станцын тендерийг бид нар ингээд 3 дахиа зарлаж байна. Урьд нь 2 удаа зарлаад зарлаад оролцогч орж ирээгүй иймэрхүү байдалтай байгаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Сангийн сайдаас л асууя даа. Нөгөө энэ гадаадын зээл тусламжийн энэ ашиглалт, энэ төсөвт өртөг ер нь яг одоо бас үнэхээр тэр цаад тал нь ингээд янз бүрийн шалтаг шалтгаан тоочоод байдаг юм уу эсвэл бид нараас шалтгаалсан юм байгаад байдаг юм уу? Энэ дээр ер нь нэг дүгнэлт мүгнэлт хийсэн бас ер нь бодож байгаа дүгнэсэн юм байдаг юм болов уу?

Г.Тэмүүлэн: Нэмж хариулт өгье. Сангийн сайд.

Б.Жавхлан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя аа. Ер нь аль аль талаас нь ч шалтгаалсан, аль аль талаас нь шалтгаалаагүй буюу 3 дахь хүчин зүйл нь байгалийн давтагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж байгаа зүйлүүд ч байдаг. Жишээ нь сая энэ 10 аймгийн дулааны станцууд дээр бол аймаг болгон дээр нөхцөл нөхцөлүүд нь өөр байгаад байгаа. Сая бүр 10-т нь гэж онцолж хэлж байгаа жишээ нь Архангай аймаг дээр бол тэр одоо байгаа шугам нь хувьчлагдчихсан. Тэгээд тэрэнтэйгээ маргааны асуудал нь нөгөө тал нь тэр хувьчлаад авчихсан нэгэнт авчихсан улсууд нь тэрийгээ шийдүүлж өгөхгүй гэх мэт төрийн байгууллагуудаас шалтгаалахгүй ийм зүйлүүд ч байна. Мөн үнэхээр яг өнгөрсөн сүүлийн нэг энэ 5 жил бол дэлхий нийтээрээ л хэлэхээс өөр аргагүй л энэ ковидын нөхцөл байдалд дайрлаа шүү дээ. Одоо бид нар энийг зугтааж чадахгүй бодит байдалд үнэнтэйгээ тулаад л хамгийн том шалтгаан болоод өнгөрсөн 5 жилийн хугацаанд энэ л байлаа.

Төрөөс шалтгаалж байгаа энэ.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя 2 номер.

Б.Жавхлан: Төрөөс шалтгаалж байгаа нэг том дутагдал байгаа. Энэ бэлтгэл ажлаа дутуу хангадаг. Бэлтгэл ажлаа дутуу хангаж зураг, зураг төсөв, орон нутгийн тэр газар чөлөөлөлт гээд л маш олон зүйл биднээс өөрсдөөс шалтгаалдаг. Энэ бүхнээс болоод төсөвт өртөг нэмэгдэх хугацаа алдах гээд олон эрсдэлүүд үүсдэг. Төсөл болгон дээр энэ айл өөр өөр байдаг. Төсөл болгон дээр өөр өөр.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Ганбат гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Зээлийн хэлэлцээр орж ирсэн энийг бид дэмжих ёстой юм байна гэж би ойлгоод байгаа юм аа. Нийт энэ том төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зээлийнхээ 66 орчим хувийг нь бид авахаар хэлцлээ хийчихсэн. Одоо энэ 34 хувьтай нь тэнцэх хэмжээний зээлийн хэлцлээ хийж байж энэ том төсөл иж бүрнээрээ ашиглалтад орж өгөөж нь хүртэх болоод байгаа байхгүй юу. Тийм учраас энэ зээлийн хэлцэл анх хийгдэхдээ бас их сонин юм билээ. Ашигласан зээлдээ 1.75-аар хэлцэл хийгдчихээд ашиглаагүй байгаа зээлийн үлдэгдэлдээ 0.5-аар хүү төлөхөөр ийм ерөнхий хэлцэл явчихсан. Тийм учраас аль болохоор зээлийн ашиглалтыг шуурхай явуулж, шуурхай ашиглалтад оруулж байж зээлийн үйлчилгээний төлбөрийн дарамтаас бид гарах, эргээд үр өгөөжөө хүртэх бололцоо боломж нь бүрдэх юм байна гэж ингэж хараад байгаа.

Тийм учраас дэмжье гэж. Гишүүдийн яриад байгаа олон асуудал байгаа. Үнэхээрийн төвөгтэй юм бий. Энийг бид дотооддоо нэлээн сайн анзаарч тэр Их Хурлын Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр байгаа ажлын хэсэг нь ч тэр Засгийн газар дээр байгаа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр байгаа ажлын хэсэг нь ч тэр энэ нэг 4 багц ажлаа хооронд нь уялдуулж график хугацааныхаа хүрээнд чанартай бүрэн дуусгах тал дээр нэлээн сайн онцгой анхаарч ажиллах шаардлага байгаад байгаа. Энэ дээр тавьдаг хяналт юмнуудаа нэмэгдүүлэх хэрэгцээ байна гэж.

Дараагийн нэг зүйл энэ том төслүүдэд дандаа гаднын гүйцэтгэгчтэй байгаад байдаг. Тэгээд зээл авч ашигласныхаа төлбөрийг хүүг бид төлөөд явдаг. Нөгөө айлын гүйцэтгэгч нар графикт хугацааны хоцрогдол үүсгээд байхад тэр нөхцөл дээр үүрүүлдэг ачаалал байхгүй яваад байгаа явдал ихээхэн хариуцлагагүй байдлыг бий болгоод байгаа шүү. Энийг энэ төсөл дээр ч тэр тэр Солонгосын 10 аймгийн дулааны станцын төсөл дээр ч тэр аль алин дээр нь нэлээн хатуу барьж ер нь цаашид энэ том төслүүд дээр гадаадын зээл тусламж авч ашиглах тэрийг дагасан гүйцэтгэгчтэй байгуулдаг гэрээ хэлцэл энэ юмнуудаа энэ өмнө явсан төслүүдийнхээ туршлага, сургамж, үр дагавар дээрээ нэлээн сайн үндэслэж гэрээний эрх зүйгээ боловсронгуй болгохгүй бол бид бүгдэд ер нь нэлээн тийм төвөгтэй нөхцөл байдлыг бий болгоод хүсэн хүлээж байгаа үйлчилгээ бүтээгдэхүүнээ хүртэх бололцоог удаашруулаад байна шүү гэдгийг зориуд хэлмээр байна.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн үг хэлье.

Ч.Анар: Би уг нь Монгол Улсын Сангийн яаманд Монгол Улсын хамгийн мундаг мэргэжилтнүүд байдаг гэж боддог юм уг нь. Гэхдээ одоо ингээд ДЦС-ын материалуудыг авч үзсэн. Шинэ цахилгаан станцын өргөтгөл, нефтийн үйлдвэр, хиймэл дагуул маш олон ийм хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрүүд орж ирээд байгаа

байхгүй юу. Тэгээд миний хувьд бол энэ өнгөрсөн 24 жилийн хугацаанд маш олон нийтдээ бараг 200 орчим сая долларын хөрөнгө оруулалт зээлийн хэлэлцээрт орсон байна. Гэтэл энэ засаг гэдэг болиөөрөө олон улсад дандаа хөнгөлөлттэй зээл, хамгийн баталгаатай сан, баталгаа гаргагч зээлдэгч байдаг. Тэгээд энэ зээлүүдийг харахаар сайд нар нь бүгдээрээ ингээд энэ зээл нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй, эргэн төлөлт нь хойшилсон гэдэг халхавчтай. Гэхдээ яг ингээд харахаар дандаа нөгөө төслийнх нь өртгүүд нь дандаа 2-оос 3 дахин өндөр. 2-оос 3 дахин өндөр тэгээд хүү багатай шүү дээ төсөвт суугаагүй шүү дээ энэ чинь захын балансын санхүүгийн мэдлэгтэй хүн энийг чинь ялгана шүү дээ. Тэгээд нэг ийм нөгөө хөнгөлөлттэй хугацаа нь хойшилсон гэдэг нэрийн доор өндөр төсөвтэй гаднын зээл тусламж авдгаа болих ёстой болсон байх аа.

Тэгээд одоо чадвартай боловсон хүчин байгаа юм чинь энэ хэлэлцээр хийх чадвар нь дутаж байгаа гэж бодохгүй байна. Одоо бид нарын мэддэггүй янз бүрийн шахаас дарамт улсын төсвийн нөхцөл байдал байдаг юм уу. Мэдэхгүй одоо энэ нефтийн үйлдвэр дээр тэр коммитмент пи 0.5 гэдэг бол шууд зээл авсан өдрөөсөө л давхар хүү төлөөд эхэлж байгаа. Тэгээд энийгээ гүйцэтгэлийг нь сайн төлөхгүй бол ер нь зүгээр л мөнгөө гадагшаа гаргадаг л хэлэлцээрүүд хийх гээд байна. Одоо цаашдаа дахин дахин ийм олон гаднын зээл тусламжийн санхүүжилтийн өндөр өртөгтэй төслүүдийг оруулж ирэхийгээ багасгах байх гэж Сангийн сайд Сангийн яаманд хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Үг хэллээ тэ. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Яах вэ тэгээд нөгөө төрийн нэр барьсан хэсэг нөхдүүд тэгээд юу хийгээд ямар юманд хүрдэг нь л тэгээд энэний нэг жишиг л дээ энэ газрын тосны үйлдвэр бол. Хэзээ ч тийм амжилттай болж байгаагүй. Сүүлийн 7, 8 жилд бол Засгийн газрын өр 2 дахин нэмэгдэж байгаа. Одоо бараг 8, 9 тэрбум хүрсэн байх. Цаашдаа ч энэ нэмэгдэх юм байна л даа. Одоо 35 тэрбум долларын өртэй Монгол Улс нийтдээ. Засгийн газар 9 тэрбум байх. Одоо цаашдаа нэг 3, 4 жилийн дараа энэ ч өснө. Ийм болчихлоо. Тэрбум 700 сая доллароор энэ үйлдвэрийг босголоо гэсэн нэр зүүгээд ажиллах ч юм уу, түүхий эд нь ч хаана ч байгаа юм. Өнөөдөр ингээд асуулт асуухад бол асуултад хариулж байгаа юм алга.

Энэ хариулж байгаа, хариулж чадахгүй байгаагаас үзэхэд бол энэ бүтэлтэй болно гэсэн тийм итгэл үнэмшил төрүүлэхгүй байна. Тэгээд энийг ард түмэн л үүрдэг юм. Ард түмэн л төлдөг юм гээд. Энэ нэг 2026, 2027 онд эрхбиш нүүрсний үнэ бага байх. Тэрнээс хойшоо унаж эхэлнэ. Тэр нь хэнд ч ойлгомжтой. Тэгээд энэ их өрийг чинь дараа нь яаж төлөх юм бэ? Энэ ашиглалтад ороод нефть байхгүй, түүхий эд байхгүй гэж хэлнэ. Эсвэл технологи нь таарсангүй гэж хэлнэ. Тэгээд баахан хүн орон шоронгоор дуусахгүй байх. Бодвол тэгээд. Уул нь бол хариуцлагаа үүрээд Ардын нам засаглаад ингээд дуусгах ёстой сонголтыг ард түмэн хийчихсэн Үндсэн хуулийнхаа дагуу. Гэтэл одоо манайхаас нэг АН-ын нэртэй 7, 8 нөхдүүдийг сайдаар аваачиж тавиад тэр бүтэхгүй төслүүдээ бүгдийг нь толгойлуулаад явж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ хүмүүс чинь ороод тэрийг дуусгана гэсэн баталгаа хаана байгаа юм. Дуусгаж чадахгүйг нь мэдээд тэгж тавьж байгаа байхгүй юу. Би тэгж бодож байна тэгж үзэж байна. Ёстой Ванга шиг хэлчихье. 3 жилийн дараа бид нар ахиад нэг 300 сая доллар нэмнэ гэсэн юм яриад л сууж байна. Ийм л юм болно шүү дээ. Яагаад вэ сөрөг хүчин гэж алга, хариуцлага тооцох юм гэж алга. 8 жил ингэж явсан.

Эрх мэдэл дээр тэр байх хугацаагаа уртасгахын тулд ард түмэн нь засаглах эрхийнхээ дагуу сонголтоо хийчихсэн. Тэр сонголтыг нь хэрэгжүүлдэггүй хариуцлагаас зугтаж байгаа байхгүй юу. Тэр ковидын үе гээд л түлхээд байх юм. Манай урд хөрш чинь ковидын үеэр төмөр замынхаа сүлжээг 10 дахин өсгөсөн шүү дээ. Тэр Хөх хот гээд энүүхэн энд байгаа шүү дээ. Бас л адилхан Монголчууд тал нь амьдардаг байх. Тэр чинь метротой болчихсон байгаа шүү дээ. Ингэж амжилттай хийж чадаад байгаа байхгүй юу. Тэгтэл манайд тийм юм ерөөсөө алга байна шүү дээ.

Авлига хороол сүндэрлэж байна. Хариуцлага тооцож байгаа юм алга. Нөгөө усан парк нэртэй эхлээд л юу болж дуусав. Чуулган дээр үг хэлэх боломж байхгүй аягүй хүнд сурталтай. Өдрийн өмнө нэр усаа өгч гэх шиг тиймээ. Тэр шөнө дэлхий эргээд хонож байна шүү дээ. Ийм л байгаа юм л даа. Одоо энийг засаж залруулах ёстой. Сөрөг хүчин, энэ олон намын систем энэ ардчилал энэ тэр чинь ажиллахгүй байна аа. Үндсэн хууль энэ тэр чинь. Яг ийм нөхцөлд зээлийг нэмээд ингээд аваад байх нь нэг их сайн биш ээ. Энэ чинь одоо зээлээ нэг центийг нь дутаахгүй төлүүлнэ шүү дээ дараа нь. Тэгээд энэ тусгаар тогтнолоо энэ эрх чөлөөгөө, энэ ардчиллаа бид нар алдана шүү дээ. Тэгээд мөнгөтэй болчихсон хэдэн нөхдүүд тэгээд шорондоо суух юм уу эсвэл гадагшаа гараад явчих юм уу?

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн үг хэллээ.

Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн дарга үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр чухал гэдэг агуулгаар нь авч үзэх юм бол маш чухал төсөл. Өнөөдөр бид нар урд хөршөөсөө өргөн хэрэглээний бараа экспортын хувьд бараг 100 хувийн хамааралтай болчихсон байна. Хойд хөршөөсөө эрчим хүч, түлш шатахуунаар 100 хувийн хамааралтай. Эдийн засгийн хувьд тусгаар улс гэхэд бэрх ийм болчихсон. Тэр агуулгаараа харах юм бол энэ маш чухал төсөл өө. Энэ удаж байгаа олон шалтгаан байгаа удааширч байгаа. Бидний арчаагүйгээс гадна гадаад хүчин зүйл ч байгаа гэж бид бодох хэрэгтэй. Энэ төсөл явах юм бол бид нар адаглаад нэг зүйлээрээ хараат бус болж эхэлнэ. Ер нь ковидын үед бид нэг юм ойлгосон шүү дээ. Юугаа ч үйлдвэрлэж чаддаггүй. Эдийн засгийн хувьд гадаад ертөнцөөс бараг 100 хувь хамааралтай ийм улс байгаа байхгүй юу. Энийг багасгаж байж л бид нар энэ Монгол орныг Монгол орон шиг авч явна. Тэр талаасаа харах юм бол түлш шатахуун хамгийн чухал зүйл. Тэгээд энэ төслийг бол бид нар эцсийн гарт л хөөцөлдөж хийхийн төлөө хичээх хэрэгтэй.

Тэгэхдээ энэ төслийг гацаах шалтгаанууд гарч болзошгүй. Тийм учраас би та нарыг даргын зөвлөл дээр байхад хэлсэн шүү дээ. Энэ үнэ өсөөд байгаа явдал чинь нэг шалтгаан болчихож магадгүй. Магадгүй энийг өсгөөд идэж уух гэж байна гэдэг гүтгэлэг явуулаад ингээд наад төсөл чинь нурж магадгүй. Тийм учраас энэ үнэ өсөж байгаа шалтгаануудаа энэ 2 Байнгын хорооны гишүүдэд бодитой тэр тооцоо судалгаагаа мэдээллээ гаргаад тараа гэсэн. Тэгж тараах хэрэгтэй. Яагаад өссөн шалтгаан чинь яг юу юм гэдгээ. Тэгж байж энэ төсөл цаашаа явна шүү. Энэ төслийг гацаах дотоодын, гадаадын бүрэн хүчин зүйлүүд байгаа. Бидэнд үнэ цэнтэй нандигнах эрхэм зүйл гэж байх ёстой Монгол хүнд. Тэрний нэг энэ байх ёстой. Бид нар өнөөдөр тийм зүйлгүй болчихоод байна шүү дээ. Гаднын юм бүрийг магтаад л, батлуулаад л байдаг, батлуулаад л байдаг. Өөрсдөд нь байх ёстой зүйл дээрээ тэгж хичээж чаддаггүй. Тэгээд энэ бол бидэнд байх ёстой зүйл мөн. Эдийн засгийн тусгаар тогтнолыг бий болгох нэг суурь дэд бүтэц бол энэ.

Өнөөдөр бид нар хүнс өргөн хэрэглээндээ байна шүү дээ 800-аас 900 сая доллар хэрэглэж байгаа гаднаас. Гэтэл бидний машин тэрбум гаруй доллар хүнсэндээ хэрэглэж байгаа. 1.8 тэрбум. Бидний эдийн засгийн бүтэц буруу байгаагийн нэг шалтгаан энэ шүү дээ. Машин тэрэг нь хүнээсээ их хүнс хэрэглэдэг Монгол орон. Нэгэнт одоо ингээд буруу гаж зам руу явчихсан. Хамаг валютыг чинь сорж байгаа юм юу вэ? Нефть шатахуун 1.8 тэрбум доллар, 2 тэрбум хүрч байгаа юм шиг байна. Машин нь хүнээсээ их иддэг. Ийм Монгол орныг бид нар бий болгочихсон байж байгаа.

Тэгэхээр адаглаад одоо энэ нэг гадагшаа урсаж байгаа энэ их мөнгөө багасгая гэх юм бол бид нар нефтийн үйлдвэртэй болох хэрэгтэй. Нефттэй бөгөөд гаднаас нефтээ импортолдог орон Монгол. Ийм шалгууруудаар харах юм бол бид нар үнэхээр утгагүй амьдарч байна шүү дээ. Утгагүй амьдарч байна. Тэгээд хэдүүлээ хичээж байгаад энэ нэг нефтийн үйлдвэрийг барьчих хэрэгтэй. Бидэнд эрхэмлэх зүйл гэж байх ёстой шүү. Тийм зүйл байдаг бол тэрний нэг нь энэ эрчим хүч, түлш шатахууны хувьд хараат бус болох явдал байх гэж би бодож байгаа юм.

Тийм учраас Монголчууд энэ дээр одоо нэг чигт байж зүтгэл гаргаж байж сэтгэл гаргаж байж энэ төсөл хэрэгжинэ.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулна.

Хоёр Байнгын хорооны хамтарсан хуралдаан 32 гишүүн ирцэд орсон байна. Байнгын хорооны танхимд одоогоор 17 гишүүн байна. 17 гишүүнээр санал хураалт дэмжигдэх ёстой.

Хоёр Байнгын хорооны гишүүдийг ирж саналаа өгөхийг хэл дуулгаарай. Ажлын албанаас утасдаарай. Гишүүдийг ирэх хүртэл яах вэ товчхон саналаа хэлье гэж бодож байна. Яах вэ 2 Байнгын хорооны, Төсвийн байнгын хороо болоод Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааныг бол гадаад зээл тусламж дээр бол бид нар хийдэг болсон байгаад байгаа юм. Зээлийн хэлэлцээр дээр. Энэ тэгээд 2023 оны 7 сард батлагдсан Төсвийн шинэчлэлийн хуулийн хүрээнд өмнөх парламентаас баталсан хуулийн дагуу энэ гадаад зээл тусламжийн ашиглалтыг сайжруулах үүднээс хяналт хариуцлагыг сайжруулах үүднээс бол бид нар энэ мэргэжлийн Байнгын хорооныхоо саналыг буюу Төсвийн байнгын хорооныхоо саналыг заавал ч үгүй сонсож эцсийн шийдвэрийг гаргадаг байх үүднээс бол бид нар энэ хамтарсан Байнгын хорооны хуралдааныг бол хийдэг болсон.

Тэгээд өнөөдөр бол шинэ парламентын хамгийн анхны энэ 2 Байнгын хорооны хамтарсан хурал бол болж байгаа гэдгээр онцлогтой байна. Энэ бол нэг талдаа төсвийн шинэчлэлийн хүрээнд энэ гадаад зээл тусламж ашиглалтыг сайжруулах үүднээс бол хийгдэж байгаа, хийгдсэн томоохон өөрчлөлтийн бол бодит нэг үр дүн гэж харж байгаа. Тэгэхээр өнөөдөр бол үндсэндээ энэ хуучин өмнөх хуулийн хүрээнд бол зөвхөн зүгээр Төсвийн байнгын хороо санал, дүгнэлтээ хүргүүлдэг байсан. Үндсэн өр зээлүүд удирдлагынх нь асуудал дээр нь хариуцлагыг нь хүлээдэг Байнгын хороо нь Төсвийн байнгын хороо байдаг. Төсвийн байнгын хороон дээр дэмжигдээгүй байсан үр ашиггүй магадгүй цаашид санхүүжүүлэх

шаардлагагүй байсан төслүүд дээр бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо эсрэг шийдвэр гаргаад явдаг ч гэдэг юм уу ийм жишгүүд бол байсан. Тэгэхээр энийг бол бид нар сэргийлэх үүднээс цааш цаашдаа энэ зээлийн хэлэлцээрүүд бол дандаа хамтарсан Байнгын хорооны хурлаар эргээд 2 талаас нь 2 мэргэжлийн Байнгын хороо хамтарч шийдвэрээ гаргадаг ийм жишиг бол тогтож байгаа гэдэг бол зүйлийг хэлэх байна. Энэ ч үүднээсээ сая гишүүд хэлж байгаа саналуудыг та бүхэн анхаарч байгаа байх.

Нэг талдаа газрын тос боловсруулах үйлдвэрийг үгүйсгэж байгаа гишүүн бол нэг ч байхгүй байгаад байгаа. Өнөөдөр магадгүй Монгол Улсын Засгийн газар дээр хүлээлттэй байгаа хэрэгжиж байгаа энэ 80 орчим төслүүд дотроос гадаад зээл тусламж ашиглалт авч байгаа зээл тусламжит төсөл хөтөлбөрүүд дотроос бол хамгийн номер нэгт хэрэгжих ёстой төсөл бол энэ газрын тос боловсруулах үйлдвэр байгаад байгаа.

Тэгэхээр энэ үүднээсээ бол хэлж байгаа энэ саналуудыг бол та бүхэн анхаарч үзээрэй. Зардлын өсөлттэй холбоотой асуудлуудыг ярьж байна. Хугацаатайтэй холбоотой, хяналт хариуцлагатай холбоотой ер нь том зургаараа бол нь зээл тусламж, үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой ач холбогдол эрх ашгийн эрэмбээр нь санхүүжүүлдэг байх гэдэг асуудлыг ярьж байгаа юм.

2025 оны төсөв батлагдсантай холбогдуулаад бид нар бас яг энэ Улсын Их Хурлын тогтоол гарсан. Энэ тогтоол дээр хоёрдугаар улиралдаа багтааж Засгийн газар бүх ашиглагдаж байгаа болон ашиглагдахаар хүлээгдэж байгаад байгаа гадаад зээл тусламжтай холбоотой асуудлуудаа хоёрдугаар улиралдаа багтааж оруулж ирж эрэмбэлж шаардлагагүй асуудлуудаа ч гэсэн царцаах гэдэг юм уу эрэмбэлэх энэ асуудлуудаа бол Улсын Их Хурлаар оруулж шийдвэрлүүлье гэсэн асуудлыг тавьж байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр бол онцгой анхаарч дараа дараагийн асуудлуудаа бол явуулаарай. Нэг зүйлийг протоколд хэлэхэд бол анх удаагаа би энэ 2 Байнгын хорооны хамтарсан хурал болж байгаа учраас дараа дараагийн зээлийн хэлэлцээрүүд орж ирэхэд энэ дараах нөхцөлийг тусгасан эсэхийг бол хянан хэлэлцэнэ гэсэн энэ дэгийн тухай хууль дээр бид нар заалтыг энэ 2023 оны 6 сард оруулж өгч байсан байх 7 сард. Энэ өөрөө юу юм гэхээр тухайн тэр зээлийн зориулалтыг тодорхой тусгасан байх гэж бодож байгаа юм. 76.3 дээр.

Хоёрдугаарх нь тэр зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байх ёстой гэж байгаа юм. Тэгээд тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр заавал ч үгүй байж байж энд Улсын Их Хурал руу орж ирж шийдвэр гаргуулдаг байна шүү гэсэн асуултыг тавьж гарч ирж байгаа юм. Энэ дотроо бол улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, импортыг орлох, экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт болон зөвхөн үр ашигтай төслийг санхүүжүүлэхэд энэ чиглэгдсэн байх ёстой гэдэг асуудлыг бол гадаад зээл тусламж дээр бол тавьж гаргаж өгсөн байгаад байгаа.

Залгуулаад энэ тухайн зээлийн хэмжээнд төсвийн тусгай шаардлагын тогтоосон хэмжээнд нөлөөлөх буюу гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байх ч гэдэг юм уу энэ зохицуулалтууд бол заавал ч үгүй энэ зээлийнхээ

хэлэлцээрийн энэ баримт бичиг дотроо бол тусгагдсан байна гэсэн асуудлыг тавьсан байгаа.

Гишүүд орж ирсэн байна.

Анхны санал хураалт учраас туршилтын санал хураалтыг эхлээд явуулж үзье. Гишүүд анхааралтай байгаарай. Эхний туршилтын санал хураалт.

Санал хураалт.

Ерөнхийдөө болж байна тэгэхдээ төхөөрөмж өөрөө их удаан байна. Сая бол нэлээн удаж байж юу гарч ирж байна.

Санал хураалтыг явуулъя. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын 4 дүгээр багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

Энэ төхөөрөмж алдаатай байна. 100 хувь бүгдээрээ дэмжээгүй юм шигээр нь гарч ирж байна. Техникийнхэн төхөөрөмжөө янзлаарай. Эргээд буцаагаад өгөх төхөөрөмж бэлэн болсон үед дахиад мэдэгдье. Сая бол 100 хувь алдаатай санал хураалт бол гарч ирж байна. Горимын санал гаргая. Батжаргал гишүүн гаргах уу? Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Санал хураалтын тоног төхөөрөмж алдаа заагаад ажиллахгүй байна аа. Тийм учраас энэ чухал асуудлыг санал хураалтаа гар өргөж санал хураалт явуулахаар шийдэж өгөөч гэж хүсэж байна аа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн горимын санал гаргасан. Төхөөрөмж гэмтэлтэй ажиллахгүй байгаад байгаа учраас гараар санал хураалтыг бол явуулъя гэсэн санал явуулж байна. Батжаргал гишүүний саналыг эхлээд горимын саналаа дэмжээд аваадахъя. Тэгээд дараа нь түрүүнийхээ санал руугаа орно гэсэн үг. Батжаргал гишүүний горимын саналыг дэмжье гэдэг саналаар санал хураалтыг явуулъя.

Хуралдаанд 20 гишүүн оролцож байгаа юм байна тоолъё. 20 гишүүн оролцож байгаа. 20-оос 20. Тоогоо хэлээрэй. Горимын саналыг дэмжиж байгаа. 32-оос 20 гишүүн горимын саналыг дэмжсэн байна.

Горимын санал дэмжигдсэн учраас гараар санал хураалтыг явуулна аа. Тэгээд түрүүн төхөөрөмж ажиллаагүй. Гэхдээ бол яах вэ ажиллаагүй ч гэсэн дахиад бол баталгаажуулаад бол өмнөх санал хураалтыг бол хүчингүй болгоё гэдэг санал хураалтыг бол явуулах зайлшгүй шаардлагатай байгаа. Дамдинням гишүүн гаргачих уу? Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Дарга аа өмнөх санал хураалт техникийн саатлаас болоод миний санал жишээ нь би энэ зөвшөөрсөн гэдгээр өгсөн байхгүй юу тэгээд эсрэг

гараад байгаа байхгүй юу. Тийм учраас өмнөх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Тэгээд дахин санал хурааж өгнө үү?

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд Дамдинням гишүүний саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Төхөөрөмж 100 хувь ажиллаагүй. 100 хувь эсрэг гарсан.

Дамдинням гишүүний саналыг өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэдэг саналаар санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад 32-оос 20 гишүүн оролцож, 20 гишүүн дэмжлээ.

Ингээд энэ санал хураалт дэмжигдсэн учраас түрүүн томъёоллыг уншсан. Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 32 гишүүн оролцсоноос 19 гишүүн дэмжсэн байна. Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

16.57 цагт

Дараагийнхаа асуудалд орцгооё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хоёр дахь асуудал. [Монгол Улс олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах Эрчим хүч-3 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье.](#)

Зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна. 2 номер.

Б.Жавхлан: Эрхэм Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрчим хүч-3 буюу Багануур Чойр чиглэлийн 188 км 220 квт-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам дээр дэд станцын өргөтгөх төсөл нь Алсын хараа 2050 Монголын Улсын урт хугацааны хөгжлийн бодлого шинэ сэргэлтийн бодлого болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний өндөр ач холбогдолтой төсөл. Засгийн газрын зүгээс тус төслийн зээлийн хэлэлцээрийг Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкттай 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хийж Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. Төслийг Дэлхийн банкны 47 сая амдолларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд тус зээл нь софтвер буюу баталгаат санхүүжилтийн хүү дээр 1.44 хувийн нэмэгдэлтэй хувьсах хүүтэй 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх 25 жилийн хугацаанд эргэн төлөлт хийх нөхцөлтэй юм аа.

Зээлийн хөрөнгийг өөрийн удирдлагын тухай хуулийн 24.3-д заасны дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчийн ХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн болно. Төслийг хэрэгжүүлснээр

Багануур Чойр чиглэлийн 110 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг 2 дахин нэмэгдүүлж, Багануур, Чойр, дэд станцуудын өргөтгөн эрчим хүчний чанар найдвартай ажиллагаа тогтвортой байдал хангагдахаас гадна өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа зүүн бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг саадгүй хангах боломжийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх ач холбогдолтой юм аа. Иймд Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд Эрчим хүч-3 төслийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн шийдвэрлэж, дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны гишүүн, Батсүмбэрэл гишүүн, танилцуулна аа.

Л.Батсүмбэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Монгол Улс болон олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах эрчим хүч 3 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ. Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс энэхүү эрчим хүч-3 төсөл буюу Багануур, Чойр чиглэлийн 188 км 220 квт-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцыг өргөтгөх төсөл хэрэгжсэнээр Багануур-Чойр чиглэлийн 111 квт-ын цахилгаан станц цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг нэмэгдүүлж ба Багануур-Чойрт дэд станцуудыг өргөтгөн эрчим хүчний чанар найдвартай ажиллагаа тогтвортой байдал хангагдахаас гадна өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг хангах боломжийг бүрдүүлнэ гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Энхцэцэг, Соронзонболд, Бадамсүрэн нарын гишүүд асуулт асууж хариулт авч санал хэлсэн болно. Монгол Улс болон Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах Эрчим хүч-3 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн танд баярлалаа.

Зээлийн хэлэлцээртэй холбогдуулаад Засгийн газраас орж ирж асуудал танилцуулж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сангийн яамных түрүүн танилцуулсан. Түрүүний адил хэвээр байгаа. ЭХЯ-наас Эрчим хүчин сайд Чойжилсүрэн сайд байна, ЭХЯ-ны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт, ЭХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Энхтүвшин, ЭХЯ-ны Цалхилгаан дамжуулах үндэсний сүлжээний компанийн захирал Дашдаваа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байгаа юм байна аа. Зээлийн

хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Хосбаяр гишүүнээр тасалъя. Анар гишүүн асуулт асууна.

Ч.Анар: ЭХЯ Чойжилсүрэн сайдаас асууя. Энэ төслийг дэмжиж байгаа. Монгол Улсад 220-ийн шугам зайлшгүй хэрэгтэй байгаа. Нэн шаардлагатай төсөл. Зүгээр яагаад Бөөрөлжүүт-Багануур 2-ын хооронд 220 шугам татагдчихсан байгаа тийм ээ? Тэгвэл Бөөрөлжүүтээсээ Чойр руу татах юм бол 117 км болоод дахиад Бөөрөлжүүтийн чинь хажууд Баянгийн цахилгаан станц эрчим хүчний нийтдээ 1.2 гегаваттын эрчим хүчний эх үүсвэр үүсэж байгаа. Тэгэхээрээ тэндээ эрчим хүчний зангилаа цэгээ хийх юм бол энэ төсөл чинь өөрөө өртөг нь багасаад илүү шугамын алдагдал багатай зангилаа цэг болох ёстой байсан юм биш үү? Энэ яагаад ямар шалтгаанаар одоо дахиад Бөөрөлжүүтээсээ Багануур татаж байгаа бараг параллелийн дахиж шууд урагшаагаа Чойр руу шугам татах гээд байгаа юм. Энэ нь ямар үндэслэлээр ингэж орж ирсэн юм бол тэрийг тодруулах гэсэн юм? Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Анар гишүүний асуултад хариулъя аа.

Одоо баригдаж байгаа Бөөрөлжүүтийн станцаас Багануур руу 220 киловольтын хос шугам татаад ашиглалтад авчихсан байгаа, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ бид нар бас өөрийн чинь ярьж байгаагаар Багануур-Бөөрөлжүүт-Чойр гээд явчихсан бол тодорхой хэмжээний хэмнэлт гарах байсан юм. Гэтэл энэ Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк тэргүүтэй энэ олон талт донор байгууллагууд яг нүүрсний станцаар дамжаад явчихсан болохоор ТУЗ дээрээ дэмжигдэхгүй байх магадлал өндөр байгаад байсан. Тийм учраас энэ төслөө нураахгүйн тулд бид нар юу Бөөрөлжүүдийнхэн та нар Багануур руу татчих гэдэг ийм шийдвэр гаргасан.

Хоёрдугаарт Багануур маань ерөөсөө айхтар том газар зүйн хувьд бол хамгийн том ийм юу цэг болж байгаа. Багануураас дахиад зүүн аймгууд руу Өндөрхаан Дорнод руу бид нар ийм 220 киловольтын шугам татахаар би Засгийн газрын мөрийн хөтөлбөрт сууцчихсан байгаа учраас ийм шийдвэр гаргаад явсан.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Тэгэхээр нүүрсний цахилгаан станцыг холбох гэж байгаа биш шүү дээ. Тэр Бөөрөлжүүт Баянгийн дунд дэд станцаа тавиад урагшаа холбоё гэдэг байдлаар хэлцлээ хийж болох уу? Тэндээсээ жишээ нь Багануур биш эрчим хүчний нэг гридийнхээ тойргийг харах юм бол Сэргэлэн рүү холбох юм бол Улаанбаатар руугаа ч эрчим хүчний алдагдал багатай, тэгээд зүүн бүс рүүгээ ч холбож болохоор байгаа шүү дээ. Энэ хэлэлцээрт энэ оролт өөрчлөх бололцоо байгаа юу боломжгүй болсон уу?

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Бараг боломжгүй гэсэн ийм дүгнэлт гарч байгаа. Яагаад гэвэл хэрвээ дахиад энэ төслийг ТЭЗҮ-ийг шинээр хийгээд эхлэх юм бол доор хаяж 3-аас 4 жил болно. Дэлхийн банкны процедур нь нэгдүгээрт ийм.

Хоёрдугаарт бид нар энийг тооцоод бид нар Баянгийн цахилгаан станцыг Городок гэж нэрлэдэг. Тэр Налайх руу татаж байгаа. Сэргэлэн гээд 220 киловольтын цахилгаан дамжуулах дэд станц баригдаж байгаа тэр рүү татчихаж байгаа юм. Тэгэхээр энэ схем нь бол түүгээрээ хангагдаж байгаа гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн дарга асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Энэ сэргээн босголтын банкаар явж байгаа төсөл нөгөө сэргээгдэх эрчим хүчтэй холбогдолтойгоор миний үед яригдаж байсан төсөл мөн үү, нэгдүгээрт. Тэр мөн үү гэж. Хэрвээ мөн бол энэ дээр нэг ийм асуудал байгаад байгаа юм. Энэ чинь ингээд Багануураар дамжаад Улаанбаатар руу ирнэ шүү дээ. Тэгээд Багануурт чинь бас байнгын ажиллагаатай Бөөрөлжүүтийн 100 мвт-ыг дамжуулдаг болно гэсэн үг. Тэгэхээр Бөөрөлжүүт үнэхээр ашиглалтад ороод ингээд яах юм бол Бөөрөлжүүт чинь байнгын ажиллагаатай байхаас өөр аргагүй болж эхэлж байна шүү дээ. Ингээд дээрээс нь одоо тэр урд талын нарны станцуудын энэ чадлуудыг багтаагаад Улаанбаатар руу ирүүлж чадахгүй байна шүү дээ багтахгүй.

Тэгэхээр тэр үед яах вэ бид нарын нэг ярьж байсан юм гэвэл Багануур-Улаанбаатарын ахиад хос хэлхээ шугам ярьж байсан байхгүй юу. Тэгэхээр энэ хос хэлхээ шугам чинь баригдахгүй бол тэр рүү Багануур руу энийг татаж аваачаад наашаа энэ бүх чадлыг авчирч чадахгүй.

Хоёрдугаарт зүүн бүс бол яах вэ ингээд нөгөө миний үед эхлүүлсэн Чойбалсангийн 50 орчих байх тийм үү? Тэгвэл нэг хэсэгтээ хангалттай. Тэгээд зүүн тал руу энийг чинь нэг шингээх тийм эрэлт хэрэгцээ бол бага. Тэгээд энийг хот руу л ашиглах ёстой байхгүй юу. Тэр сэргээгдэх гишүүний эх үүсвэрүүдийг. Тэгээд ингэж харах юм бол Багануур Улаанбаатарын холбосон шугамын асуудал зайлшгүй гарч ирээд байгаа юм. Тэгээд энэ асуудал нь ер нь яаж шийдэгдэж байгаа юм бэ гэж асууж байна. Тэгэхгүй бол одоогийн Багануур-Улаанбаатарын шугамаар энийг бол бүгдийг нь дамжуулах бололцоогүй.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Даваасүрэн дарга даргын асуултад хариулъя аа.

Та яг зөв ярьж байна. Багануураас-Улаанбаатар руу дахиад 220-ын шугам татах ийм шаардлага үүсчхээд байгаа учраас бид нар энэ шугамыг нь түрүүлээд тэр Баянгийн цахилгаан станцаас Городок руу 330 шугам татах тийм тооцоолол гарч ирж байгаа. Сэргэлэн рүү 330 болгож байгаа. Ингэж байж энийг багтаах юм байна лээ. Баянгаас Налайх руу 330. Баянгаас Сэргэлэн рүү 330 киловольтын шугам татах ийм тооцоолол гарч ирсэн. Баянгаар дайрахгүй энэ чинь дайрахгүй шүү. Баянгаас Сэргэлэнг рүү татах 330. Сэргэлэнгээсээ дахиад юу руу 330 байхгүй юу Сонгино руу 330 татах шаардлагатай. Баянгаас нөгөөдөх нь Налайх руу оруулж ирж байгаа. Улаанбаатар дэд станц байна шүү дээ. Улаанбаатар дэд станц руу 330-аар авчирна. Дахиад өргөтгөх шинэ 330 станц бид нар ТЭЗҮ хийж байна.

Баян, Бөөрөлжөө 2 хоорондоо холбогдох байх.

Г.Тэмүүлэн: Тодруулъя нэмж Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Яах вэ энэ шугамыг чинь тэгэхээр нөгөө гол агуулга бол тэр нөгөө Сэргээн босголтын банкттай ярьсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг төв рүү нийлүүлэх тэр шугам мөн юм байна шүү дээ.

Тэгэхээр наадах чинь өөрөө шууд Чойроос Багануур гээд холбогдчихоор чинь баян хамаагүй болчихно шүү дээ. Тэгэхээр харин тийм. Тийм учраас энэ Багануураас наашаа Улаанбаатар руу авах гэхээр энэ шугам чинь даахгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд тэрийгээ яаж зохицуулж байгаа юм гэж асуухад тэнд чинь өшөө Бөөрөлжүүт орж ирж байна.

Дээр нь нэмэгдээд энэ зүүн өмнөд бүсийн сэргээгдэх эрчим хүчний энэ чинь бараг нэг 70, 80-аад юм орж ирэх байх тийм үү? Дээр нь 50 мвт-ын салхи орсон уу ороогүй юу. Орчихсон бол энэ чинь нартайгаа 100 гараад явчихна. Тэгээд энэ бүгдийг Багануураар дамжуулаад авах тийм шугам байхгүй шүү дээ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Ажлын хэсгээс 6 номер.

Б.Дашдаваа: Бүгдээрээ сайн байцаана уу? Сая яригдаж байгаа Бөөрөлжүүтийн нэгдүгээр багц нь бол Багануурын станцтай холбогдсон. 2 нь Сэргэлэнтэй холбогдохоор байгаа. Баянгийн дэд станц бол эхний ээлжид Чойрын 220-той холбогдоно. Тэгээд Улаанбаатар руу сая ярьж байгаа. Налайх дээр баригдах 200, 330 болж байгаа. Энэ шугамаар холбогдоно. Тэгээд энэ яг энэ хуучин Алтан гурвалжин гэдэг шиг энд бол ийм Алтан гурвалжин үүсэж байгаа. Энэ ДЦС-ын хувьд 1560 мвт, сэргээгдэх эрчим хүчний хувьд бол 150-аад мегаваттын энэ урсгалыг зохицуулах ийм шугам болно. Тэгээд энэ Багануур-Чойрын энэ 2 хэлхээтэй 220-ийн шугам бол одоо байгаа шугам нь 207 гээд. 240 мм квадратын огтлолтой ийм нэг хэлхээтэй шугам байгаа. Энэ шугамын.

Г.Тэмүүлэн: Минут нэмээд өгье 6 номер.

Э.Дашдаваа: Энэ 220 киловольт 50 киловольтын шугам Багануур, Бөөрөлжүүтийн хооронд барьж байгаа энэ районд байгаа энэ сэргээгдэх эрчим хүчний болон дулааны цахилгаан станцын урсгалуудыг концепцыг бүрэн зохицуулах ийм шугам болно. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

Ц.Даваасүрэн: Саяын ярианаас би ингэж ойлголоо. Баян, Чойр 2-ыг нэмж холбох юм байна гэж ойлголоо тийм үү? Тэгээд Баянгаа наашаа ахиад холбох юм байна шүү дээ тиймээ? Сэргэлэн рүү. Тэгэх юм бол энэ Чойр, Багануурын шугамын чинь ач холбогдол бараг байхгүй болчих гээд байна шүү дээ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 6 номер.

Э.Дашдаваа: Горимын хувьд бол тасралт бусад ачаалын урсгалын хувьд бол энэ шугам зайлшгүй байж байж энэ гурвалжин зоорь хэсгийг ажиллахаар гаргасан байгаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд нэмж тайлбар өгье. Чойжилсүрэн.

Б.Чойжилсүрэн: Даваасүрэн дарга аа энэ Баян-Багануур 2-ын хоорондоо холбох тийм төлөвлөлт байхгүй байгаа байхгүй юу. Баян, Чойр 2-ыг холбоно. Гэхдээ тооцооллоор диспетчерийн үндэсний төв цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ манай Эрчим хүчний яамныхан бүгд яриад энэ нь оновчтой байна гэдгийг Дэлхийн банктэй энэ төслийн судалгаанд сүүлийн 2 жил би Эрчим хүчний яаманд байх үед бол ажлын хэсэг гаргаад ийм дүгнэлт оруулж ирсэн юм. Энэ нь оновчтой байна гэдгээр.

Г.Тэмүүлэн: Заяаболд гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Надад 2 асуулт байгаа юм аа. Нэг нь Сангийн яамнаас нэг нь ЭХЯ-аас 2 асуулт асуух гэж байгаа юм. Тэгэхээр энэ Дэлхийн банкнаас олгож байгаа энэ ялангуяа хөгжлийн зээл урт хугацаатай, хүү багатай, хөнгөлөлттэй ийм зээлүүдийг бол дэмжих нь зөв өө. Энэ зээлийг бол тэр агуулгаараа дэмжиж байгаа. Ялангуяа энэ зээлийн зарцуулалт нь өөрөө нийтийн дэд бүтцийг барьж байгуулахтай холбоотой ийм зээл учраас энэ зээлийг бол дэмжсэн ийм байр суурьтай байгаа гэдгийгээ илэрхийлье.

Хоёрдугаарт нь энэ зээлийг бид нар ингээд аваад байдаг. Сая бид нар өмнө нь яг энэ газрын тосны зээл авлаа. Ингээд зээл аваад байдаг. Энэ зээлийн ашиглалтыг явуулах гэхээр зэрэг нөгөө хязгаартаа тулчхаад байдаг. Сая Сангийн яамныхан маань ингээд хууль бие даасан хууль оруулж ирнэ гэдэг ийм асуудал ярьж байна. Энийг дагаад төсвийн тодотголын асуудал ярина. Эсвэл төсвөөс гадуур санхүүжилтийн асуудлууд ингээд яригдахаар болчих гээд байна л даа.

Тэгэхээр би энэ зээлийн ашиглалтыг сайжруулах үүднээс өнөөдөр Монгол Улсад хэрэгжүүлж байгаа нэг 90 орчим төсөл байгаа. Энэ дээрээ дахиж Сангийн яамныхан маань анализ хийгээд хугацаа уртассан, зээлийн үр ашиг, ач холбогдол нь буурчихсан ийм төслүүдийгээ хүчингүй болгох чиглэлээр ажил оруулж ирвэл судлаад Их Хурал дээрээ танилцуулга хийвэл яадаг юм бэ гэсэн ийм санал асуулт байгаа юм. Үндсэндээ сая бол энэ зээлийн ашиглалт хугацаа уртасах тусмаа л зээлийн ашиглалт ихсэх тусмаа л тэгээд л үр ашиггүй төсвийн мөнгө үргүй зарцуулах ийм л нөхцөл байдал руу бид нар орж ирэх ийм үүд үүд хаалга нээгдээд байгаа юм аа.

Тийм учраас энэ дээр бол бид нар зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хязгаарыг нэмэгдүүлэх үүднээс энэ хэрэгжиж байгаа төслүүд дээр эргэж анхаарвал яасан юм бэ гэдэг ийм асуулт байгаа юм.

Хоёрдугаарт нь сан ЭХЯ-аас асуухад нэг иймэрхүү нийтийн дэд бүтэц биш, хувийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой ийм төслүүд нэлээдгүй байна аа. Сая аймгуудын станцын асуудлууд яригдаж байна. Дулааны станцын асуудлууд яригдаж байна. Хэрэвзээ бид нар энэ тарифыг үр ашигтай хувийн компани өөрөө бариад ашиглаад тарифаараа ашигтай байх юм бол энийг чинь зайлшгүй зээл авахгүйгээр төр ачаалал авахгүйгээр хувийн хэвшил ийм хийх бүрэн боломж байгаа шүү дээ. Завхан аймгийн Тосонцэнгэл дээр 30 мвт-ын цахилгаан дулааны хосолсон ийм станцыг бариад явж байгаа. Тарифыг нь ашигтай хийгээд өгчихсөн учраас хувийн хэвшил хийж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Тэгвэл бусад аймгууд дээр ч гэсэн ийм дулааны станцуудыг хийгээд явах бүрэн боломжтой гэж үзэж байгаа. Эрчим хүчний либералчлал реформ гэж ярьж

байгаа энэ хүрээндээ энэ асуудлуудыг тарифыг нь чөлөөлөхтэй холбоотой асуудлуудыг хийгээд өгчих юм бол зайлшгүй төр ийм зээл авч ачаалал үүрэхгүйгээр ийм хувийн хэвшил хийх ийм боломж байгаа гэж ингэж үзэж байгаа.

Ингээд саяын тэр 90 төслүүд дээр ч гэсэн хувийн хэвшил хийх боломжтой. Орон сууц барих Баянголын аман дээр орон сууц барих гэх мэтчилэн ийм төслүүд нэлээдгүй байгаа. Зээл олгож байгаа тал дээр асуудал үүснэ гэдэг ийм асуудал яригдаж магадгүй. Хэрвээ Засгийн газрын баталгаатай байх юм бол бид өнөөдөр хаанаас ч зээл авах боломжтой байгаа шүү дээ. Энэ асуудал дээр хариулаач гэдэг ийм асуулт. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 2 Асуулт суусан.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Сая нөгөө төсөв батлагдах дагасан тогтоолд яг ийм үүрэг өгсөн байгаа. 2 том танилцуулга хийхээр байгаа. Нэгдүгээр улиралдаа багтаагаад 2024 он хүртэл хэрэгжиж байгаа төслүүдийн нөгөө өртөг нэмэгдсэн асуудлуудыг нь үлдсэн баахан төслүүд байгаа. Тэд нарыг нэг ингээд яамдуудын дэргэдэх нөгөө хөгжлийн төвүүдээр баталгаажсан төсөвт өртгөөр нь танилцуул гэдэг нэг үүрэг байгаа.

Хоёрдугаарт яг саяын таны ярьдаг энэ одоо бид чинь ирэх 2025 онд 1.5 их наяд төгрөг дотор 89 төсөл багтаахаар байгаа тэрний нэг нь сая энэ өмнө нь бага ярилцдаг дэмжүүлдэг нефть боловсруулах үйлдвэрийн төсөл байх жишээтэй. Тэгэхээр эдгээрийгээ зээлийн ашиглалтын явц нь ямар байна эрэмбэлж танилцуул. Одоо эндээс зогсоох ямар төсөл юмнууд байна, үргэлжлүүлэх ямар төслүүд байна энийгээ эрэмбэлээд танилцуулаарай гэсэн ийм үүргүүд өгсөн байгаа. Эд нартай зэрэгцээд л энэ 2 яригдана даа. Тэгэхээр тэр асуудал яг таны хэлсэнчлэн орж ирнэ гэсэн үг.

Хоёрдугаар улирал гэж хүлээхгүй дээ би хаврын чуулган эхэлмэгц л оруулъя гэж бодож байгаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Заяабал гишүүний асуултад хариулъя.

Та бол бид нар нэг эрчим хүчний үнэ чөлөөлөх тухай либералчлал хийх тухай ярьж байгаа. Сая жишээлбэл энэ оны өмнө хэлтэй амтай шүүмжлэл дагуулаад эрчим хүчний үнэ тарифыг нэг өртөгт нь дөхүүлэх тухай ийм эхний алхам хийсэн нэлээн ийм хүндрэлтэй байна. Нэг талаасаа эрчим хүчний салбар чинь монопол байгууллага хүссэн хүнээ тулгаад байх бололцоотой боловчиг энэ манай хэрэглэгчийн төлбөрийн чадвар гэж нэг ойлголтод бид нар очоод тулна. Тийм учраас энэ үнэ чөлөөлөөд магадгүй одоогоос нэг хэд хэдэн жилийн дараа эдийн засгийн нөхцөл байдал байдал маань гайгүй болсон үед үнэ чөлөөлөх юм бол таны ярьж байгаа ингээд аятайхан тариф, үр ашигтай тариф батлаад өгчих юм бол хувийнх нь салбар ороод төр зээл авахгүй гэдэг энэ бодлого бол мэдээж шилжих эхний шилжилтийн ажлууд хийгдэж байгаа юм. Энэ цахилгаан дамжуулах агаарын шугамын тухайд бол хувь компани хэзээ ч хөрөнгө оруулалт хийгээд дамжуулах шугамдаасаа өөрийнхөө үр ашгийг хүртэх тухай ярихад бол нэлээд урт хугацаа байгаа учраас ойрын жилүүддээ лав нэг энэ ойрын 10 жилдээ төр энэ цахилгаан дамжуулах агаарын шугамыг бол төр өөрийн эзэмшилд барьж байгуулж байхаас

ондоо аргагүй байх. Ер нь тэгэхэд бусад улс орнууд энэ туршлагыг хараад байхад дамжуулах сүлжээ бол ер нь голдуу төрийн мэдэлд байгаа бусад улс орнууд дээр байдаг учраас энэ жишгийн дагуу энэ зээл орж ирж байгаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Багануураас Чойр хүртэл ингээд 220-ийн шугам татчих юм байна зээлийн хэлэлцээрээр. Цаашаа Мандалговь, цаашаа Арвайхээр хүртэлх энэ 220-ийн шугам энэ Дэлхийн банкны зээлийн хэлэлцээр яригдаж байгаа гэж байсан. Энэ талаар мэдээлэл өгөөч ээ. Ер нь зураг төсөл ТЭЗҮ нь бүрэн хийгдсэн юм уу? Өртөг зардлын хувьд ямар юм бэ? Энэ хангайн бүс нутаг манай Өвөрхангай аймаг энэ 220-ийн шугам ашиглалтад орж байж нөгөө эрчим хүчний бас 2 эх үүсвэртэй, 2 эх үүсвэрээс шугамтай болох ийм нөхцөл бүрдэх юм байна лээ. Нэгдүгээрт нэг ийм асуудал.

Хоёрдугаарт нь бид нар Улсын Их Хурал дээр Шинэ Хархорин хотын бүтээн байгуулалтыг дэмжих тухай хуулийн төслийг ярьж байгаа. Тэгэхээр мөн Хархорин Шинэ Хархорин хоттой холбоотой Хархорин хотыг дайраад цаашаа баруун аймаг руу явах ийм 220-ийн шугамын асуудал яригддаг юм байна лээ. Бас ТЭЗҮ, хөрөнгө оруулалт, зээлийн хэлэлцээр гээд. Тэгэхээр энэ яг ТЭЗҮ юм нь гарсан юм уу? Өртөг нь ямар юм бэ? Ер нь яг хэрэгжих хугацаа нь энэ 2 дээр хоёулан дээр нь хэдэн оноос хэдэн он хүртэл хугацаанд хэрэгжих юм бэ? Энэ талаар мэдээлэл өгөөч.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Ийм цахилгаан эрчим хүчний тухайд бол 2 эх үүсвэртэй байх найдваржилтын тухай гэх асуудал яригддаг аа. Энэ бодлогын хүрээнд говийн бүсийг ойрын ирээдүйд нэг 900 орчим мегаваттын хэрэглээ үүсэхээр тодорхой байна. Энэ хүсэлтүүд ирчихсэн, техникийн нөхцөлийн хүсэлтүүд ирчихсэн. Хэрэгжиж эхлэх гэж байгаа төслүүдийн судалгааг аваад үзэхээр ийм байгаа юм. Тийм учраас Багануур-Чойрыг 220-оор холбочихно. Чойроос-Сайншанд руу 220 киловольтын шугамын тендерийн ажил явж байна. Багануураас эхлээд Чойр, Чойр, Чойр-Сайншандыг энэ 220 киловольтын шугам нь тендерийн түвшинд явж байна. Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр тендер нь зарлагдаад ойрын жилд энэ жилээс эхлэн хэрэгжээд эхлэх байх.

Түүний дараа Сайншандаас Цагаан суваргын хооронд 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих ажлыг бид нар Европын сэргээн босголт хөгжлийн банканд судалгааг нь хийлгээд ТЭЗҮ-ийг нь боловсруулаад явж байгаа. Европын сэргээн босголт банкны удирдлагуудаас өнгөрсөн жилийн 2024 оны төгсгөлөөр ирж уулзахдаа бол дэмжих бололцоотой гэдэг ийм хариултыг өгч байгаа. Энэ ойрын жилүүддээ бид нар энэ хэлэлцээр дуусах байх. Бас Их Хурлаар оруулж ирж та бүхнээр зөвшөөрөл авах ёстой ийм болно.

Ингээд бид нар Цагаан суварга хүргэх юм бол говийн бүс рүү бид нар баруун талаараа Сонгино, Мандалговь, Тавантолгой дэд станц руу 330 шугам холбогдчихсон. Зүүн талаараа 220 киловольтын шугамаар холбогдоод ингээд 2 талын эх үүсвэртэй болох Оюу Толгойг цахилгаан эрчим хүчээр дотоодоос хангахад бол энэ техникийн шаардлага хангахуйц ийм бодлогууд хэрэгжиж байгаа юм. Таны

хувьд асуусан тэр Мандалговоос Арвайхээрийн хооронд 220 киловольтын агаарын шугам тавих дэд станцуудын холбогдох өргөтгөлийн хамт бид нар Дэлхийн банк Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк гурвууланд нь хүсэлт тавьчихсан байгаа. Хамтраад та бүхний Монгол Улсад шилжүүлэх орон зай дотор энэ шугамыг хэрэгжүүлж өгөөч гэдэг ийм хүсэлтүүд тавьчихсан байгаа. Энэ шугамын ач холбогдлыг сая та өөрөө яг тайлбарлачихсан учраас илүү нурших нь илүүц байна.

Түүний дараа нэг шугамын асуудал ярьдаг. Яг Мөрөнгөөсөөс Улиастайн хооронд 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын хос шугам барья гэдэг ийм мөрийн хөтөлбөрт суусан дараа нь Улиастай, Говь-Алтай руу холбох ийм ажил юу хийж байгаа. Түүнээс гадна Мянгад Улиастайн хооронд 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамын асуудлыг бол эх үүсвэр нь шийдэгдчихсэн байгаа. 95 орчим сая доллароор барина гээд. Гэхдээ энэ маань төсөл маань үр дүн, үр ашиг багатай байгаа учраас бид нар яг тэргүүн ээлжид түлхэж лоббидож гүйхгүй байгаа. Тэгчих юм бол Монгол Улс нэгдсэн нэг системтэй болох ийм бололцоо бүрдэнэ. Баруун бүс маань Алтай Улиастайтайгаа, тэгээд төвийн бүстэй холбогдчихно.

Зүүн тийшээ Налайх, Өндөрхаан, Чойбалсан гээд явчих юм бол зүүн бүсийн эрчим хүчний систем, төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбогдоод үе үеийн эрчим хүчний юу салбарынхны хүсэл мөрөөдөл болсон Монгол Улс тусдаа 4 эрчим хүчний систем байгаа бол нэгдсэн нэг эрчим хүчний систем юмтай болох энэ бодлогууд явж байгаа юм. Тэгэхээр тэр зээлжих орон зайгаа энэ тэрийгээ бодоод, үр ашгаа бодоод эхний ээлжид энэ төслүүд эхнээсээ ингээд хэрэгжээд явж байгаа ийм л байдалтай байгаа.

Хархорины саяын асуудлын хүрээнд шийдэхэд чинь Арвайхээр холбогдчих юм бол.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя. Жавхлан сайд 2 номер.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье дөө. Чойжилсүрэн сайд бараг хариулчихлаа даа. Мандалговь, Арвайхээрийг яг одоо ТЭЗҮ нь эцэслээд ер нь хийгдэж байгаа гэж бид нар мэдээлэл авсан. Албан ёсоор манай дээр ирээгүй байгаа. Ирмэгц нь энэ дунд хугацааны хөтөлбөр дээрээ Дэлхийн банктай тохиролцсон нийт зээлийн дүн дотор багтаагаад бид нар зээлийн хэлэлцээрээ хийнэ. Ер нь дүн нь 1 км-т ноогдуулах цахилгаан дамжуулах агаарын шугамын үнэ нь ойролцоо гарч байгаа сурагтай байна лээ. Эдний саяынх энэ дээр бол нэг 250 орчим. Мандалговь, Арвайхээр дээр бас 260-270-ын хооронд гарах юм шиг байна гэж бид нарт урьдчилсан байдлаар мэдээлэл ирсэн.

Тэгэхээр хаврын чуулганаар энэ орж ирэх байх. Түрүүн Анар гишүүн хэлж байсан. Мэдээлэл өгч бид нар амжаагүй. Тэгэхээр манай улсын хувьд бол нэг ийм юм байгаа юм шүү. Бид 2012 он хүртэл ерөнхий хэлэлцээрүүд дээр дандаа нөгөө бага орлоготой буурай орны хөгжилтэй улсуудтай ижил нэн хөнгөлөлттэй зээлийн ийм ангилалд орж авч ирсэн. 2012 оноос хойш бид нар энэ Медлингин каунтрис буюу энэ дотроо бас дахиад нөгөө нэг лоу медел, апер медел гэж 2 ангилалтай байдаг. Бид нар лоу меделд нь 2012 оноос 2024 он хүртэл энэ ангилалд нь яваад бас эндээ таарсан хөнгөлөлттэй зээл авдаг байсан бол 2024 оны энэ 3, 4 дүгээр улирлаас эхлээд 2025 он эхэлмэгц бид нар дээд талын шатад орчихсон. Дээд талын шатад орохоор бид нарын авдаг нөгөө зээлийн нөхцөлүүд маань нэлээн чангарч

ирсэн. Бид нарын хувьд бол хүндэрч ирж байна. Илүү их хариуцлагатай болж ирж байх ийм цаг хугацаа руугаа бид нарын тоолуур эхэлж байна гэсэн үг.

Дээрээс нь одоо энэ төслүүд дээр та харж байгаа байх. Ялангуяа ийм дэд бүтцийн төслүүд дээр бол энэ дэд бүтцийн яамдууд маань бүгд өөрсдөө ийм хажуудаа эрдмийн зөвлөл хөгжлийн төвүүдтэй байдаг. Барилга хөгжлийн төв, Эрдэс баялаг, мэргэжлийн зөвлөл. Эднийх одоо мөн эрчим хүчний мэргэжлийн зөвлөл, зам тээврийн хөгжлийн төв гээд тэндээс гарч ирсэн ТЭЗҮ энэ зураг төсөв энэ бүгд дээр бид нар ямар ч өөрчлөлт хийж чаддаггүй. Тэнд хуулиар олгогдсон тусгай лиценз бүхий мэргэжилтнүүд экспертүүд энэ үнэлгээ энэ ТЭЗҮ-үүд хийгддэг.

Салбарын энэ сайд нар нь ч бараг оролцож чаддаггүй байх. Энэ бол яг эцсийн ийм дүгнэлт байдаг. Ингээд энэний цаана бид нар 2 үндсэн суурь бичиг баримтаа харж байгаа. Дунд хугацааны хөтөлбөр мөн бид хөгжлийн хөтөлбөр дотроо хамаа орсон уу үгүй юу гэдгийг эдгээр шалгууруудыг харж байгаад л яг зээл авах, зээлийн хэлэлцээр зээлийн нөхцөлүүд дээр энэ нь бол яг Сангийн яамны үүрэг болж 2 талт, олон талт хөгжлийн институцуудтэйгээ хэлэлцээр хийж эцэслэж оруулж ирдэг байгаа.

Энд оруулж ирээгүй маш олон төслүүд байгаа. Бид нар эрэмбэлэгдээд ялангуяа энэ шинэ Их Хурал эхэлснээс хойш бол бид дандаа дэд бүтцийн асуудлуудаа оруулж ирж байгаа. Орхигдсон оруулж ирээгүй бид яг бид нарын түвшинд эрэмбэлэгдээд хасагдсан олон төслүүд байгаа. Тэр талаар энд тэр болгон мэдээлэл бид нар мэдээлэл өгөөд байдаггүй, шаардлагагүй гэж үздэг. Орж ирж байгаа төслүүд бол хамгийн л эрэмбэлэгдэж орж ирж байгаа нэн шаардлагатай эдийн засгийн өндөр ач холбогдолтой төлбөрийн тэнцлийн ч өндөр ач холбогдолтой ийм төслүүд орж ирж байгаа гэдгийг мэдээлэл өгье.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ер нь яах вэ тэр дамжуулах шугам сүлжээ төрийн мэдэлд байх энэ дээр хөрөнгө оруулалт хийх найдвартай болох энэ тэр гэдэг дээр бол санал нийлж байна, дэмжиж байна аа. Энэ зээл маань тэгээд ямар өртөгтэй ямар хугацаатай авч байгаа зээл билээ? Хэдий хэмжээний зээл билээ? Тэрийг нэг тодруулаад өгчхөөч. Тэгээд нөгөө талаар бол эрчим хүчний үнэ чөлөөлнө гэж байхгүй. Эрчим хүчний үнэ нэмж байгаа гэж та хэлчих шиг боллоо. Мэдээж хэрэг монопол болохоор тэр чинь үнэ л дээ. Эрчим хүчнийхээ үнийг одоо ингээд нэмээд тулгалт л хийж байгаа байхгүй юу. Тэрнээс ч чөлөөлөөд чөлөөт зах зээл дээр эрчим хүч нь өрсөлдөөд үнэ нь бууж байгаа тийм юм байхгүй. Өнөөдөр энэ Мэнийгээ арай эрт хийчихсэн юм уу яасан ийсэн юм мэдэхгүй байна. Ямар ч байсан энэ утаан дээр бол нэмэгдэх нь энэнд нөлөөлж байгаа.

Хуучин бол цахилгаан дулааны үнэ гайгүй бага байх үед бол цахилгаан хэрэглээд энэ утааны юу бага ч гэсэн байх ийм боломжтой байдаг байсан. Энэ дээр одоо бас нэг жоохон тийм болчих шиг боллоо л гэж бодож байна. Уул нь ийм их мөнгөтэй Засгийн газар их мөнгө олж байгаа гэсэн мөртөө ийм хүнд хэцүү үед ингэж байгаа нь харамсалтай л байгаа юм. Нөгөө талаар бол тэр Багануурын цахилгааны станц уул нь орчих байсан юм. Тэр нь одоо хэнтэй нь холбоотой юм. Даваасүрэн сайдтай холбоотой юм уу? Тантай холбоотой юм уу? Төр бол тэр тухайн үедээ тэрийг хийчих ийм боломжтой байсан. Одоо энэ нүүрсний цахилгаан станцуудад зээл өгдөг хүмүүс гэж маш ховор болсон. Одоо яг энэ үед бол бид нар Монгол Улсад

яг хэрэгтэй байгаа тэр Эгийн голын УЦС-ыг оруулчихмаар байгаа юм. Энэ их олон жил ярьж байгаа мөртөө оруулдаггүй, хийдэггүй.

Нэгдүгээрт ногоон эрчим хүч гэж тэндээс гарна. Нөгөө талаараа бол энэ эрчим хүчний тохиргоог бол тэрэн дээр хийж болж байгаа байхгүй юу. Ийм асуудлыг өнөөдөр амжуулаад хийчих тийм сэтгэл байна уу. Энэ дээр та бүхэн юу бодож байна вэ гэдгээ асуучихъя. Тэр Багануурын станцыг оруулаагүй эрчим хүчний үнэ ийм болгосон энэ тэрдээ бол нэг уучлалт гуйчихмаар байгаа юм ард түмнээсээ та бүхэн маань.

Нөгөө талаар бол энэ орон нутагт энэ дулааны станцууд хэрэгжиж байгаа Баянхонгор, Архангай, Өвөрхангай яг хэзээ орох юм бэ? Энэ дулааны станцууд. Тэр утаа бол яг Улаанбаатар шиг болсон шүү дээ. Тэгээд орон нутагт яг л адилхан нөгөө олон жил байсан Ардын намын голцуу нөхдүүд ихэнх нь нүүрсний станцтай жижиг жижиг. Тэгээд төсвөөс тэр мөнгөө авч байдаг. Нэг их хурдан оруулах сонирхолгүй юм шиг байгаа юм. Энэ ямар шатдаа явж байна яаж ажиллаж байна? Эрчим хүчний сайд нэгэнт орж ирсэн юм чинь ийм 2, 3 зүйлийг тодруулаад асуучихъя аа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Эгийн голын усан цахилгаан станцын талаар маргаан гарч байгааг та бүхэн мэдэж байгаа. ОХУ Юнейскод гомдол гаргасан. Эгийн голын УЦС-ыг барьж байгуулснаар Байгаль нуурт сөрөг нөлөөлөл үзүүлэх юм байна гэж байгаль орчинд. Тэрний дагуу Юнейскогоос бид нар манай Монгол Улсын Засгийн газарт ийм гомдол ирсэн байна. Хариу гээд Монгол Улсын Засгийн газар Цранцын нэг компанийг сонгон шалгаруулаад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн юм байна лээ. Энэ компанийн дүгнэлтээр бол Эгийн голын УЦС-ыг барьж байгуулахад Байгаль нуурт бол ямар нэг тийм сөрөг нөлөөлөлгүй гэдэг ийм дүгнэлт ирсэн. Энэ дүгнэлтийг ОХУ-ын Эрчим хүчний сайд байсан Шульгинов гэдэг хүнд би бүрэн эхээр нь хүргүүлсэн.

Оросын талаас бол Франц компанитай бол бид нар Францын компанийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрмөөргүй байна аа. Найрсаг бус харилцаатай улс орон. Манай 2 хөрш орон учраас 2 улсын Засгийн газрын 2 улсын эрдэмтдийн баг гаргаад энэ асуудлыг шийдье гэдэг ийм тохиролцоог төрийн өндөр түвшний уулзалтын үеэр тохиролцсон. Тийм учраас ОХУ-ын талаасаа Байгаль экологийн яам нь манай талаасаа Монголын талаасаа Байгаль орчны яам хамтраад энэ ажлын хэсэг явж байгаа. Дүгнэлт нь ойрын жилүүд энэ ойрын хугацаанд бол нэг талдаа гарах байх гэж найдаж байгаа. Ингээд ОХУ-тай учраа олчих юм бол Эгийн голын УЦС-ыг цаашид үргэлжлүүлэх санхүүжилтийг явуулах гэх мэт асуудлууд яригдана аа.

Багануурын ДЦС-ын тухайд бол энэ 700 мвт-ын цахилгаан станцын төсөл хэрэгжиж явж байгаад төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь Хятадын цөмийн энергийн энергийн корпорац гэдэг ийм байгууллага байна л даа. Би сайд болоод 2 удаа энэ байгууллагынхантай уулзсан. Үндсэн тайлбар нь бол манайх бол зөвхөн цөмийн энергийн салбарт үйл ажиллагаа явуулна. Хятадын Төрийн өмчийн хорооны тэр компанийн дүрэм өөрчлөгдсөн гэдэг байдлаар энэ төслийг хэрэгжүүлэх бололцоогүй байна гэдэг ийм хариултыг өгдөг. Тэгээд энэ төслөө та нар яах юм бэ зогсоолгох юм уу гэхээр бид нар энэ төслийг цаашид хэрэгжүүлэхээр дахиад дотоодын ийм хэрэглэгч нарыг одоо хайж байна аа. Удахгүй тэр төслийг шилжүүлэн өгөх компаниудтай учраа ололцоод хэлэлцээрээ дуусгаад Монголын талтай

уулзана гэдэг ийм хариултыг өгч байгаа. Өнөөдрийг хүртэл ийм байдалтай явж байгаа. Багануурын цахилгаан станцын тухайд.

Арвайхээрийн дулааны станцын төсөл гэж нэг ийм хэлтэй хамтын ийм асуудал явсан. Хамгийн сүүлд бид нар 2024 он ны 12 сарын эхээр байх би өдрийг нь санахгүй байна. Энэ төслийг хэрэгжүүлэх бүх сайн инженер компанийн ерөнхий захирлийг дуудаж уулзсан. Төслийн гэрээг цуцална гэдэг мэдэгдэл хүргүүлсэн. Зөрүүлээд энэ юу ерөнхий захирал тэргүүтэй төлөөлөгчид ирсэн. БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд бас энд оролцож бид нар улс төрийн дэмжлэг үзүүлнэ ээ. Монгол Улс Эксим банкны нэр хүнд байна. Энийг ямар ч байсан энэ компанид дуусгуулахад бид нар Солонгос улсын төр захир захиргаа бол бүх талын дэмжлэг үзүүлнэ гэдэг ийм ойлголтын хүрээнд 2026 оны 5 сарын 31-ийг дуустал бид нар гэрээг сунгаж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ 2025 ондоо энэ төслийг дуусгаад 2026 оны 5 сарын 31 гэхэд улсын комисс ажиллуулна гэдэг ийм ойлголцолтой л байгаа юм.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн. Тэгээд дараа нь тодруулчихъя. Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Ганбат гишүүний тэр Багануурын станцын энэ асуусан асуултад би хариуцлагатайгаар тодорхой хариулъя.

Багануурын станцыг намайг сайд болоод очиход бол гэрээ байгуулагдчихсан байсан. Улаанбаатарт баригдах 5 дугаар станцын төслийг зогсоогоод үндсэндээ энэ гэрээ байгуулсан байсан. Тэр үед ямар асуудал үүссэн гэхээр баахан Хятад ажилчид орж ирэх гэж байна гэдэг зүйлийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр яриад. Үнэсний аюулгүй байдлын зөвлөлөөс энэ төслийг хэрэгжүүлэхгүй байх ийм албан бичгийг Эрчим хүчний яам Засгийн газарт ирүүлсэн. Уучлал гуйх бол тэр үеийн тэр Ерөнхийлөгч нь л уучлал гуйх ёстой байх. Баттулга Ерөнхийлөгч байсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ийм ирсэн бичиг ЭХЯ-н дээр байгаа.

ЭХЯ-аас энэ төслийн ач холбогдлыг ойлгож байгаа учраас лав миний үед ЭХЯ-ны зүгээс энэ төслийг зогсох нэг ч шийдвэр гаргаагүй гэдгийг би хариуцлагатай хэлье. Нэг ч шийдвэр гаргаагүй. Сая Чойжилсүрэн сайд ч хэллээ. Энэ төсөл үргэлжлээд явж байгаа. Тэр төслийн нэгжийг татан буулгасан юм огт байхгүй.

Харин миний ойлгосноор бол 2021 онд Хятад улсын Ерөнхийлөгч Си Жиньпин гуай НҮБ-д айлчлахдаа гадаад орнуудад нүүрсний төсөлд санхүүжилт хийхгүй гэдэг ийм амлалт авсан юм байна лээ. Тэрнээс хойш энэ төсөл дээр асуудлууд үүсэж эхэлсэн. Төрийн өмчийн компани санхүүжүүлэх тийм бололцоо нь бол байхгүй гээд сая Чойжилсүрэн сайд хэлээд байна шүү дээ. Тэр компанийн зүгээс явуулж байсан идэвхжил нь буурсан юм байна лээ. Би тийм мэдээллийг авсан. Тэрнээс биш одоо ЭХЯ-ны зүгээс энэ төслийг зохиох талаар ямар нэг тийм шийдвэр гаргасан зүйл огт байхгүй гэдгийг би хариуцлагатай хэлье.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Тэгээд бүүр Үндэсний аюулгүй байдал хүртэл яригдаад явчих шиг боллоо. Тэгээд хаа хаанаа хариуцлагатай баймаар байна. Эцсийн эцэст тэгээд л энийг юуг нь ард түмэн л үүрдэг ийм нөхцөл байдалтай болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр юу байна эрчим хүч цахилгаан дулааны үнийг нэмлээ. Энэний хариуд ядаж найдвартай байлгамаар байна? Одоо тэгээд л хязгаарлаад л таслаад л ингэх юм аа. Энэ дулаахан ч байна л даа аз болоход. Цаашдаа сар шинийн өмнө энэ хязгаарлахгүй, дулааныг нь таслахгүй ийм байх боломжтой байгаа юу? Ямар байгаа вэ гэдэг зүйлийг тодруулъя аа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ганбаа гишүүн ээ одоо өнгөрсөн 34 жилээ сайн юм уу би сайн чи муу гээд ингээд хэрэлдэх юм бол бүр утгагүй юм болно. Манай ЭХЯ чинь заримдаа бол Хөдөлмөр, нийгсийн хамгааллын яамны харьяа байгууллага агентлаг шиг байсан юм байна лээ шүү дээ. Халамжийн яам гэж нэртэй бараг. Дандаа алдагдалтай явсаар байгаад ийм байдалд орчихсон. Одоо бид нар нэг ийм их төвөгтэй цаг үед амьдарч байгаа. Нөгөө талаас сонирхолтой ч байж магадгүй.

Сүүлийн 2023, 2024 онуудад манай оргил ачааллын өсөлт жилийн 12 хувь. Энэ чинь ойролцоогоор нэг 230-240 мвт байхгүй юу. ТЭЦ-3 маань өөрөө суурилагдсан хүчин чадал нь 198 мвт-ын дотоод хэрэглээгээ хасахаар 171 мвт-ын л сүлжээнд нийлүүлжлж байгаа. ТЭЦ-3-аас жил болгон нь илүү хэмжээний 230, 240 мегаваттын эрчим хүчний эх үүсвэр нэмж оруулж байж холбогдох хуваарилах байгууламж цахилгаан дамжуулах агаарын шугам хуваарилах байгууламжуудын хамт ашиглалтад.../минут дуусав.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулах уу? Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Одоо энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэглээгээ гүйцэх ийм л хүндрэлтэй байгаа юм. Одоо явж байгаа төслүүдийг тэр Баянгийн цахилгаан станц 660 мвт-ын буюу Бөөрөлжүү 600 гэх мэт энэ төслүүдийн явсан тохиолдолд бид нар 2027 оны 6 сарын 30 гэхэд ямар ч байсан хэрэглээгээ нэг баталгаатай гүйцээж хязгаарлалт хийхгүй гэдэг ийм 300 орчим мегаваттыг нь нөөцтэй болно. Тэр болтол бид нар бол хүнд нөхцөл байдалд явж байгаа. Сая дөнгөж сая бид нар Бөөрөлжүүтийн энэ 150 мвт-ын блокийг холбосон. Магадгүй гадаа орчны температур 35 градусаас нэмж хүйтэрчихгүй байх юм бол энэ өвөл бид нар хязгаарлалт хийхгүй байх бололцоо бүрдэх байх. Ийм л юм. Тэгэхдээ ямар ч төсөл та өөрөө мэдэж байгаа манай эрчим хүчний салбарт нэг цахилгаан станцыг барихад гэрээ байгуулснаас хойш хамгийн хурдандаа 36 сар ажил эхэлсний дараа хамгийн хурдтай бол 30 сарын дараа л ашиглалтад орох. Зөвхөн станцыг барихад. Мөн энэнтэй зэрэгцүүлээд.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя. Анар гишүүн.

Ч.Анар: Жавхлан сайдын тайлбарыг сонслоо. Ойлголоо. Тэгээд энд нэг процессын алдаа байгаа юм биш үү? Мэргэжлийн зөвлөл харьяа яамдууд нь хөрөнгө оруулалт худалдааны хэлэлцээр хийх чадамжгүй тэгээд шууд орж ирэхээр энэ нь бол аягүй ойлгомжгүй байна. Тэгэхээр энийг процессын хувьд дахиж харж эргэж харахгүй бол бид нар байнгын өндөр өртөгтэй нэрлэсэн үнийн төслийн санхүүжилтүүдийг хэлэлцээр хийхээс өөр аргагүй байдал процесс яригдаад байна л даа. Тэрнээс нөгөө нефтийн хүдрийг явуулах ёстой гэдэг дээр бол 100 хувь дэмжиж байгаа шүү.

Чойжоо сайдаас нэг юм асуух гэж байгаа юм. Чойжилсүрэн сайдаасаа. Энэ эрчим хүчний үндэсний компаниуд маань одоо энэ олон улсын төсөл хөтөлбөр санхүүжилтийн банкны тендерүүдэд орж чаддаггүй. Нэг үеэ бодвол эрчим хүчний угсралтын компаниуд чадавхтай болчихсон ч гэсэн энэ тендерүүдийн ийм хөрөнгийн баталгаа ажиллах үзүүлэлтэд нь нийцдэггүй. Тэрнээс болоод нөгөө дандаа Хятадын компани орж ирдэг. Орж ирэхдээ энэ төслийн байгаль орчны үнэлгээ, гадаадын зөвлөх үйлчилгээ аваад нийт төсөвт өртөг нь нэг 40 хувь орчим хувиар өсчхөөд байгаа. Тиймээ та ч мэдэж байгаа бүгд л мэдэж байгаа.

Тэгэхээр энийг хэзээнээс эхлээд нөгөө гаднын зээл тусламжаар авахаар төсөвт өртөг автоматаар үүсчэж байгаа юм. Тэгээд тендерийн сонгон шалгаруулалт нь 3-аас 4 жил болж байгаа. Тэгэхээр энийг яаж улсын төсвөөс болгоод, төсөвт өртөг багатай, үндэсний компаниудаа дэмжсэн бодлого руу хэзээ шилжих вэ? Энэ хэзээнээс боломжтой болох болоо.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Анар гишүүний асуултад хариулъя.

Яг ийм та ёстой зөв тавих ёстой асуулт тавьж байгаа. Жишээлбэл энэ Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас Чойр Сайншандын төсөл хэрэгжиж байна. Бид нар нөгөө Европын сэргээн босголт хөгжлийн банкны худалдан авалтын дүрмээрээ эхний ээлжид шорт лист гүйцэтгэхийн тулд яг сонирхлоо илэрхийлсэн. Техникийн хувьд бол энийг хэрэгжүүлэх чадвартай гэж үзсэн компаниудын жагсаалт авсан. 20 орчим компани орж ирсэн байх. Уучлаарай 18 ч байна уу. Энэ дотор нэг л Монголын компани орж ирсэн. Энэ компанийг тэр шорт листэд үлдээчих санаатай Европын сэргээн босголт хөгжлийн банктай яг би өнөөдрийн байдлаар 4 удаа энэ түрүүчийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанаас хойш 4 удаа бичиг солилцоод албан бусаар уулзаад ярьж байгаа. Энэ танай дүрмээр чинь явж байгаа компаниуд дээр Монголын танайд санхүүжүүлж байгаа гэсэн үг шүү дээ.

Монголын компани энэ босгыг чинь давахгүй байна. Монголын компаниуд давдаг шалгуурыг бууруулъя гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа. Харамсалтай нь энэ асуудлыг бүрэн шийдэж чадахгүй байгаа юм. Нөгөө талаасаа албан бусаар ярихлаар бид нар чинь бол энэ Европын сэргээн босголт хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк тэргүүтэй байгууллагуудаас голдуу зээл авдаг ийм улсууд. Тэр Европын сэргээн босголт хөгжлийн банкны худалдан авалтын дүрэм гэх юунууд дээр бол ингээд донор эх үүсвэр гаргаж яадаг компаниудын дуу хоолой бол харамсалтай нь биднийхээс илүү өндөр байгаа юм.

Тийм учраас энэ дүрмийн өөрчлөлтийг бид нар эндээсээ олон талт байгууллагууд шүү дээ Азийн хөгжлийн банк жишээлбэл хэчнээн 100 гаруй гишүүн байгууллага болсон орнуудтай. Тэгэхээр энийг өөрчлөхийн тулд бол тодорхой хэмжээний бодлого зорилт нэлээн урт хугацааны лобби хэрэгтэй юм байна лээ. Энийг бол бид нар аль болох л энэ Монголын компани энэ босгуудыг давдаг. Монголын зээл Засгийн газар зээл авч байгаа юм чинь Монголын компани шалгарчихвал үндэсний компани шалгарчихвал Монгол Улсад хэрэгтэй юм аа. Санхүүгийн хувьд, төлбөрийн тэнцлийн хувьд, хүний нөөцийн хувьд ч энэ Монголдоо үлдээчих талаар л бид нар ажиллаад байгаа.

Тэгэхээр энэ дахин хэлье. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бол бид нар тэртээ тэргүй үндэсний компаниудыг шалгаруулах энэ ийм бодлого явуулна. Энэ аргагүйн эрхэд эх үүсвэрийн дутагдалтай байгаа учраас энэ зээл олгож байгаа улсуудын худалдан авалтын дүрмийг дагаж мөрдөх шаардлага зайлшгүй үүсээд байгаа. Ийм л хүндрэл байгаа юм.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу?

Даваасүрэн гишүүнээр тасалъя. Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ яг төслөөс харахаар Чойр 3 шугамаар холбогдох юм байна л даа ерөнхийдөө тиймээ. Одоогийн байгаа 220 шугам тэгээд тийм 110-ын шугам, дээрээс нь ахиад Баян-Сэргэлэн-Улаанбаатар гэсэн нэг шугам байх нь байна. Тэгээд Багануураар дамжаад холбогдох юм байна шүү дээ. Тэгээд энэ юугаа нэг та нар эргэж хараарай. Зүгээ уг нь яг Багануурын станц ашиглалтад орсон бол яг энэ кольцо нь уг нь зөв юм байгаа юм. Эх үүсвэргүй болохоор кольцо ярихад бол тийм ач холбогдол бол муу. Тэр Ганбат гишүүний яриад байгаа эргэлзээг Чойжилсүрэн сайд арилгая аа.

Би одоо Багануурын станцаар өчнөөн гүтгүүллээ.

Хэрвээ Багануурын станцыг гацаасан ямар нэг шийдвэр би сайд байх хугацаандаа гаргасан байгаа албан ёсоор Ганбат даргад гаргаж өгье өө. Хэрвээ би тийм шийдвэр гаргасан байх юм улс төрийн хариуцлага хүлээе ээ. Тэгж хүнийг гүтгээд байж ерөөсөө болохгүй. Энэ төсөл бол Багануурын энэ асуудал бол Хятадын тал нүүрсний төслийг санхүүжүүлэхгүй гэсэнтэй холбоотой үүссэн асуудал. Би Си Жиньпин биш шүү дээ. Би НҮБ дээр очиж үг хэлээгүй шүү дээ.

Тийм учраас энэ Си Жиньпинтэй андуураад байгаа энэ андууралыг нэг таслан зогсоогоод хэрвээ би ямар нэг шийдвэр гаргасан байдаг юм бол гаргаж өгье. Би улс төрийн хариуцлага хүлээхэд бэлэн. Ингэж худлаа гүтгүүлээд байж болохгүй.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулъя.

Санал хураалт гараар явж байгаа. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтыг явуулж эхэлье.

Байнгын хорооны танхимд нийт 20 гишүүн байна. Монгол Улс олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах Эрчим хүч-3 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Гишүүд санал хураалт.

Гараар санал хураалтад 20 гишүүн дэмжлээ 32 гишүүн оролцсоноос.

Ингээд энэ асуудал дэмжигдлээ. Ажлын хэсэг болоод Байнгын хорооныхоо гишүүддээ баярлалаа.

Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ. Баярлалаа та бүхэнд.

17.45 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА